

**ХҮНИЙ ЭРХИЙН МЭДРЭМЖТЭЙ ПАРЛАМЕНТЫН
ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТОЙМ СУДАЛГАА:
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

Ц.Норовдондог (Ph.D.), Д.Аюуш, Э.Дашзэвэг

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

- Хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагаа
- Парламентын хяналтыг бэхжүүлэх
- Парламентын зүгээс НҮБ-ын хүний эрхийн тайлагнах механизмд оролцох оролцоог нэмэгдүүлэх нь
- Олон нийт ба хүний эрхийн бусад байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АБГББХ	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо
БОХХААБХ	Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо
БСШУБХ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо
ЁЗСХБХ	Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо
ЕНБД	Ерөнхий нарийн бичгийн дарга
ЗГ	Монгол Улсын Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НББХ	Нийгмийн бодлогын байнгын хороо
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОУПХ	Олон улсын парламентын холбоо
ӨБХ	Өргөдлийн байнгын хороо
ТББ	Төрийн бус байгууллага
ТББХ	Төрийн байгуулалтын байнгын хороо
ТБХ	Төсвийн байнгын хороо
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
УИХ	Улсын Их Хурал
УИХТГ	Улсын Их Хурлын Тамгын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮББХ	Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
ХЗБХ	Хууль зүйн байнгын хороо
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХШҮГ	Хяналт шинжилгээ, үнэлгээний газар
ХҮЭК	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс
ХЭДХ	Хүний эрхийн дэд хороо
ХЭЗГ	Хууль, эрх зүйн газар
ХЭНБҮ	Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ
ХЭХҮХ	Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр
ЭЗБХ	Эдийн засгийн байнгын хороо
ЭЗДШХ	Эрх зүйн дүн шинжилгээний хэлтэс

УДИРТГАЛ

Олон Улсын Парламентын Холбоо (ОУПХ) нь хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлын зарчим, хэм хэмжээ, механизмыг улс орнуудын парламент хэрхэн хэрэгжүүлж байгааг үнэлэхэд зориулсан парламентын өөрийн үнэлгээний аргачлалыг НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газар (ХЭДКГ) болон бусад байгууллагуудтай хамтран боловсруулж, үе шаттайгаар хэрэглээнд нэвтрүүлж байна.

Энэ хүрээнд ОУПХ-ны боловсруулсан аргачлалын хүрээнд хүний эрхийн болон жендэрийн мэдрэмжийн асуудлаарх 2 төрлийн үнэлгээг хамтатган Монгол Улсын парламент, ажлын алба зохион байгуулав.

Хүний эрхийн өөрийн үнэлгээний аргачлал нь хүний эрх болон Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ) хоорондын уялдаа холбоонд тулгуурлан олон улсын хүний эрхийн механизмаас өгсөн зөвлөмжийг харгалзан үзэхэд нь парламентад дэмжлэг үзүүлэх зорилготой. Улсын Их Хурал, түүний Тамгын газарт хийх хүний эрхийн өөрийн үнэлгээ нь олон улсад энэ чиглэлээр хийгдэх анхны үнэлгээ болсон.

ОУПХ-ны 2022-2026 оны стратегид заасны дагуу парламентуудын нийтлэг ашиг сонирхлыг хангах чиглэлээр хамтын ажиллагааг бэхжүүлэх үндэс суурийг тавих зорилгоор 2022 оны 08 дугаар сард ОУПХ болон Монгол Улсын Их Хурал харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Энэ хамтын ажиллагаа нь хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй парламентыг бүрдүүлэх замаар парламентын шийдвэр, үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахад чиглэнэ. Хүний эрх, жендэрийн асуудал нь Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөний Стратегийн зорилго 3-т “Улсын Их Хурал төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, парламентад итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэх.” бодлогын зорилгод хамаарах юм.

Судалгааны зорилго:

Монгол Улс дахь хүний эрх, тэгш байдлын талаарх тойм судалгаа, мэдээлэл бэлтгэх. Тойм судалгааг Өөрийн үнэлгээний дагуу дараах үндсэн асуултуудын хүрээнд гаргав. Үүнд:

- Хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагаа
- Парламентын хяналтыг бэхжүүлэх
- Парламентын зүгээс НҮБ-ын хүний эрхийн тайлагнах механизмд оролцох оролцоог нэмэгдүүлэх нь
- Олон нийт ба хүний эрхийн бусад байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь.

АСУУЛТ 2: Хүний эрхийг дэмжих талаар хууль тогтоомж гаргаж байгаа юу? (Хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагаа)

2.1.Хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийг үнэлж дүгнэх, эсхүл эрх зүйн шинэчлэлийг санаачлах эрх парламентад бий юу?

2.2.Хүний эрхийн суурь 10 гэрээ, тэдгээрийн Нэмэлт Протоколыг Засгийн газар соёрхон баталсан эсэхийг парламент тогтмол үнэлж дүгнэдэг үү? Хэрэв тийм бол, тухайн улс эдгээр олон улсын механизм, арга хэлбэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа алхмыг хийсэн үү?

2.3.ХЭҮК байдаг уу? Хэрэв байдаг бол өнөөгийн байдлаар Парисын зарчмыг хэр хэмжээнд дагаж мөрдөж байгаа вэ?

2.4.Улс орны эрх зүйн тогтолцоо, үндэсний бодлого болон үйл ажиллагаа нь ардчилсан орон зайг хэр зэрэг хамгаалж, иргэний нийгмийг үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх боломжоор хангадаг вэ?

2.5.Парламент аливаа ялгаварлан гадуурхалд хамгийн их өртөж болзошгүй тодорхой бүлгүүдийн талаар болон эрх тэгш байдал, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хамгаалахтай холбоотой Системийн сорилтуудын талаар мэддэг үү?

Сүүлийн 12 сарын хугацаанд:

- Парламент хүний эрхийн талаар тодорхой зохицуулалт бүхий хууль тогтоомж батлах буюу нэмэлт, өөрчлөлт оруулсан эсэх, мөн бүс нутгийн/ олон улсын хүний эрхийн гэрээг баталсан уу? Хэрэв ийм хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бол эдгээр нэмэлт, өөрчлөлт нь батлагдсан уу?
- Хүний эрхийн гэрээ, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталсан уу?
- Парламент эмзэг бүлгийн иргэдийн эрхийн хамгаалалтыг сайжруулах зорилготой хууль тогтоомжид үнэлгээ хийх, эсхүл баталсан уу?

АСУУЛТ 3: Парламентын хяналтыг бэхжүүлэх нь

3.1.Танай улсад хүний эрхийн үндэсний хэмжээний хөтөлбөр, стратеги байгаа юу?

3.2.Танай улсын Үндсэн хууль, эсхүл бусад хууль тогтоомжоор парламент нь асуулга авах, сонсгол хийх, тодруулга авах, газар дээр нь очиж үзэх

зэргээр засгийн газрын хариуцлагын тогтолцоог сайжруулж чадаж байна уу?

3.3. Парламент хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүний эрхийн үр нөлөөг дүгнэх, үнэлэх журам, аргачлалыг боловсруулсан уу? Үүнд тодорхой эмзэг бүлгийн хувьд ялгаварлан гадуурхлын үр нөлөөг бий болгож болзошгүй хуулиудад хийх үнэлгээ дүгнэлт мөн багтдаг уу?

3.4. Олон улсын хүний эрхийн ямар гэрээнд танай улс нэгдэн ороогүй байгаа вэ? Танай улс нэгдэн орсон хүний эрхийн гэрээний ямар заалтуудыг түр зогсоосон бэ? Түр зогсоосон шийдвэртэй холбоотойгоор гэрээний байгууллагуудаас хийсэн сүүлийн үеийн дүгнэлт ажиглалтыг уншиж танилцсан уу?

Сүүлийн 12 сарын хугацаанд:

- Засгийн газар олон улсын хэмжээнд сүүлийн үед хийж буй үйл ажиллагааны талаар парламентад мэдээлэл хийсэн үү?
- Чуулганаар хүний эрхийн асуудлаар Засгийн газарт асуулт, асуулга тавьж, хангалттай мэдээлэл авч чадсан уу?
- Хуулийн хэрэгжилт хүний эрхийн хувьд үзүүлж буй үр нөлөөг үнэлэх асуудлыг тогтмол (чуулганаар/ хорооны хурлаар) хэлэлцдэг үү?
- Хүний эрхийн тодорхой асуудлаар парламент судалгаа хийх, асуулга явуулах, эсхүл баримт нотолгоо илрүүлэх ажлыг хийсэн үү? Хэрэв тийм бол, эдгээр ажлын үр дүн, үр нөлөө юу байв?

АСУУЛТ 5: НҮБ-ын хүний эрхийн тайлагнах механизм дахь Парламентын оролцоог нэмэгдүүлэх нь

5.1. Парламентад тухайн улс ба НҮБ-ын хүний эрхийн мониторингийн байгууллагын хоорондын хамтын ажиллагааны статусыг баталгаажуулах механизм байгаа юу? (тухайлбал, парламентын хүний эрхийн хороо, ажлын хэсэг, бүлэг, тусгай комисс)

5.2. НҮБ-ын хүний эрхийн мониторингийн байгууллагын талаар парламентад байнга мэдээлэл өгдөг үү? Парламентын ажлын албаны ажилтнууд, ХЭҮК, иргэний нийгмийн байгууллагууд холбогдох мэдээллийг тогтмол авах боломжтой байдаг уу?

5.3. Парламент, эсхүл эрх бүхий хороо улс орны хүний эрхийн тайланг боловсруулахад оролцдог уу?

5.4.Хүний эрхийн гэрээний байгууллагуудад улс орны өргөн мэдүүлэх үндэсний тайлантай холбоотой тайлагнах хуваарийн талаар парламентын гишүүд мэддэг үү?

5.5.Олон улсын хүний эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч, төлөөлөгч парламентад ирж ажилласан эсэх. УИХ-ын гишүүдтэй уулзалт хийсэн байдал

5.6.НҮБ-ын Хүний эрхийн гэрээний хороодод хүргүүлэх тайлангийн боловсруулалт, тайлагнах процесст парламентын гишүүд орж ажилласан байдал

Сүүлийн 24 сарын хугацаанд:

- НҮБ-ын хүний эрхийн гэрээний хороодод явуулах илтгэл, тайлангийн төслийг УИХ-аар авч хэлэлцсэн эсэх талаарх мэдээлэл
- НҮБ-ын гэрээний хороод, UPR-т хүний эрхийн асуудлаарх үндэсний илтгэлийг танилцуулахад парламентын гишүүд оролцсон байдлын талаарх мэдээлэл
- Олон улсын хүний эрхийн байгууллагаас гаргасан зөвлөмж, дүгнэлтийг парламент авч хэлэлцэх процесс

АСУУЛТ 8: Олон нийт ба хүний эрхийн бусад байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь

8.1.УИХ, түүний Тамгын газраас хүний эрхийн талаар явуулдаг гол олон нийтийн арга хэмжээний талаарх мэдээ, мэдээлэл

8.2.УИХ-аас ХЭҮК-ын илтгэлийг хэрхэн авч хэлэлцсэн талаарх мэдээлэл

8.3.Парламентаас иргэний нийгмийн байгууллагуудтай тогтмол харилцдаг суваг, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл.

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

АСУУЛТ 2. ХҮНИЙ ЭРХИЙН МЭДРЭМЖТЭЙ ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**Сэдвийн тойм**

Монгол Улсын Их Хурал нь хүний эрхийг хангах үндэсний тогтолцооны гол оролцогчийн хувьд хүний эрхийн үндсэн зарчимд нийцсэн хууль тогтоомжийг батлан гаргах замаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэхэд тэргүүлэх үүрэг хүлээж байдаг. Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хууль болон олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн суурь гэрээ, тэдгээрийн Нэмэлт Протоколуудад нийцүүлэн хүний эрхийг хамгаалах үндэсний эрх зүйн орчныг бүрдүүлж, хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо, түүний бүрдэл хэсэг, механизм, институцүүдийг байгуулан ажиллуулж байна. Түүнчлэн Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд хүний эрхийг хангах, хамгаалах тодорхой зорилтуудыг дэвшүүлэн үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2000 онд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг баталж, УИХ-аас Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллага болох Хүний эрхийн Үндэсний Комиссыг байгуулсан. Тус Комисс нь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх үндэсний илтгэлүүд, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүр УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд танилцуулдаг бөгөөд тус байнгын хорооны дэргэд хүний эрхийн асуудлыг дагнан эрхэлдэг Хүний эрхийн дэд хороо ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд НҮБ-ын Хүний эрхийн үндэсний байгууллагуудын талаарх Парисын зарчимд нийцүүлэн хүний эрхийн үндэсний байгууллагын үйл ажиллагааны хараат бус байдал, гишүүдийн томилгоог улс төрөөс ангид байлгах чиглэлд дорвитой өөрчлөлт хийхийг НҮБ-аас Монгол Улсад зөвлөсний дагуу 2021 онд тус хуулийг шинэчлэн найруулж баталсан болно.

Улсын Их Хурлаас хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх нөхцөл байдал үүсгэж буй хууль тогтоомжид үнэлгээ, дүгнэлт хийх, УИХ-д өргөн мэдүүлсэн хууль, бусад шийдвэрийн төсөлд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх зэргээр учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, арилгах механизм бүрдүүлэх зорилгоор холбогдох журам, аргачлалуудыг батлан мөрдүүлж байна.

Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжилтийг хангах үе шат бүхэнд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх, эрх бүхий байгууллагаас тайлбар тодруулга авах, илтгэл, мэдээлэл сонсох, хяналтын сонсгол хийх зэрэг олон талт механизмуудыг ашиглаж байгаа хэдий ч эдгээр арга механизмуудыг тогтмол ашиглаж хэвшүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтнуудыг мэргэшүүлж чадавхжуулах, оролцогч байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах зайлшгүй шаардлага тулгамдаж байна.

2.1. Хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийг үнэлж дүгнэх, эсхүл эрх зүйн шинэчлэлийг санаачлах эрх парламентад бий уу?

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах нь түүний онцгой бүрэн эрхэд хамаардаг.

Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “зөвхөн Засгийн газар санаачлахаас бусад асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл санаачлах эрхтэй”. Иймээс УИХ-ын гишүүд хууль санаачлагчийн хувиар хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах аливаа хуулийн анхдагч, шинэчилсэн найруулга, нэмэлт, өөрчлөлтийн төслийг санаачлан өргөн мэдүүлэх эрхтэй бөгөөд түүнийгээ парламентаар хэлэлцэн батлуулах, эрх зүйн шинэчлэл хийх бүрэн боломжтой.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу Монгол Улс дахь хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, шүүх, прокурор, Үндсэн хуулийн цэц, төрийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, Хүний эрхийн Үндэсний Комиссоос бүрдэх бөгөөд хүний эрхийг хангах үндэсний тогтолцооны гол оролцогч болохын хувьд УИХ-аас хууль тогтоомжийг батлан гаргахдаа Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэхээс гадна баталсан хуулийн хэрэгжилтийн байдлыг үнэлж дүгнэх механизм ажиллуулдаг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар Улсын Их Хурлын түвшинд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх үйл ажиллагааг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар хамтран хэрэгжүүлэх (*Хууль тогтоомжийн тухай хуулийн §49.1*) зохицуулалт үйлчилж байна. Энэ хүрээнд УИХ-ын Тамгын газар (УИХТГ)-ын

Хяналт шинжилгээ, үнэлгээний газар (ХШҮГ)-аас Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” ашигладаг.

Уг аргачлалын 3.2-т зааснаар тодорхой 5 чиглэлийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж болно гэж заасан бөгөөд эдгээр 5 чиглэлийн нэг нь хүний эрх, чөлөөг хамгаалах, хангахад чиглэж байна. Тодруулбал, аргачлалын 3.2.5-д “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах талаарх үүргээ биелүүлэхгүй байгаа буюу Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж байгаа нөхцөл байдал үүссэн бол” гэж нарийвчлан заажээ.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурал, УИХ-ын гишүүн хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхтэй. Үүнд:

- Асуулт, асуулга тавих: Улсын Их Хурлын гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнд хүний эрх, эрх чөлөө хангагдаж байгаа эсэх асуудлаар бичгээр хандаж, мэдээлэл авдаг. (*Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн §12.1; §12.2*);
- Тайлан, илтгэл, мэдээлэл хэлэлцэх: Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг жил бүр, мөн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд тус тус УИХ хэлэлцдэг. (*Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн §16.1.3; §16.1.6*);
- Хүний эрхийг хангахтай холбоотой хяналтын сонсгол хийх: УИХ хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үр нөлөөг сайжруулах, хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, мэдээлэл авах, үнэлэх зорилгоор хяналтын сонсгол явуулдаг (*Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн §26.12*).

Хууль санаачлагчаас хуулийн төсөл боловсруулахдаа тус хуулийн төслийн хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр тухайн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг тодорхойлох шаардлагыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.5 дахь заалтаар зохицуулсан билээ. Энэ хүрээнд УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний 187 дугаар захирамжаар

“УИХ-д өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөлд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлал”-ыг батлан мөрдүүлж байна.

2.2. Хүний эрхийн суурь 10 гэрээ, тэдгээрийн Нэмэлт Протоколыг Засгийн газар соёрхон баталсан эсэхийг парламент тогтмол үнэлж дүгнэдэг үү? Хэрэв тийм бол, тухайн улс эдгээр олон улсын механизм, арга хэлбэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа алхмыг хийсэн үү?

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”, мөн зүйлийн 4-т “Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй” гэж тус тус заажээ. Монгол Улсын үндэсний хууль тогтоомжийн зохицуулалт Монгол Улсын олон улсын гэрээний заалттай зөрчилдвөл олон улсын гэрээг дагаж мөрдөнө. Өөрөөр хэлбэл эрх зүйн хүчин чадлын эрэмбийн хувьд зөвхөн соёрхон баталсан олон улсын гэрээ дотоодын хуулиас дээгүүр хүчин чадалтай байна гэж ойлгоно¹⁰⁸.

“Хүний салшгүй эрхтэй холбогдсон олон улсын гэрээ”-г Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн §8.1 дэх хэсэгт заасан ёсоор заавал Улсын Их Хурал соёрхон баталдаг. Түүнчлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн §7.1.3-т заасан журмын дагуу хүний эрхийн талаарх олон улсын гэрээнд нэгдэн орох, соёрхон батлах эсэх талаарх саналыг УИХ-аас байгуулдаг, хараат бус статустай байгууллага болох Хүний эрхийн Үндэсний Комиссоос УИХ-д ирүүлэх боломжтой.

Монгол Улс хүний эрхийн суурь 10 гэрээ, тэдгээрийн Нэмэлт Протоколуудаас “Бүх цагаач ажилчин, тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц¹⁰⁹-оос бусад бүх гэрээ, нэмэлт протоколыг соёрхон баталж, нэгдэн орсон.

¹⁰⁸ Монгол Улсын дээд шүүх, Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай 2008 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 09 дүгээр тогтоол

¹⁰⁹ United Nations General Assembly, International Convention on the Protection of the Rights of All Migrant Workers and Members of Their Families, 18 Dec 1990

Хүснэгт 1: Монгол Улсын соёрхон баталсан хүний эрхийн суурь гэрээ, тэдгээрийн нэмэлт протокол

№	Гэрээ, конвенцын нэр	Батлагдсан огноо	Монгол Улс соёрхон баталсан, хүчин төгөлдөр болсон огноо.
1	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ.	Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм, бусад хэм хэмжээг зөвшөөрч, 1961 оны 10 дугаар сарын 27-ны өдөр гишүүнээр элссэн юм.
2	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200A (XXI) тогтоолоор баталж, 1976 оны 03 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталж, Монгол Улсад 1976 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт I протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200A (XXI) тогтоолоор баталж, 1976 оны 03 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	Монгол Улсын Бага Хурлын 1991 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоолоор нэгдэн орж, 1991 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1989 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 44/128 тогтоолоор баталж, 1991 оны 07 дугаар сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон.	2012 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр соёрхон батлах тухай хуулийг баталж, Монгол Улсад 2012 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
3	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200A (XXI) тогтоолоор баталж, 1976 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.	1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталж, Монгол Улсад 1976 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2008 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 63/117 тогтоолоор баталж, 2013 оны 05 дугаар сарын 05-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр соёрхон батлах тухай хуулийг баталж, Монгол Улсад 2013 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.

4	Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1965 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 2106 (XX) тогтоолоор баталж, 1969 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр хүчин төгөлдөр болсон.	1969 оны 03 дугаар сарын 31-ний өдөр соёрхон баталж, Монгол Улсад 1969 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 34/180 тогтоолоор баталж, 1981 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	1981 оны 05 дугаар сарын 14-ний өдөр соёрхон баталж, Монгол Улсад 1981 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
5	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын нэмэлт протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1999 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 54/4 тогтоолоор баталж, 2000 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	1999 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, 2000 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хүчин төгөлдөр болсон.
	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт оруулсан нэмэлт өөрчлөлт	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1995 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 50/202 тогтоолоор баталсан. Одоогоор хүчин төгөлдөр болоогүй байна.	1997 оны 10 дугаар сарын 03-ны өдөр соёрхон баталсан.
6	Хүүхдийн эрхийн тухай конвенц	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 44/25 тогтоолоор баталж, 1990 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	1990 оны 07 дугаар сарын 05-ны өдөр соёрхон баталж, Монгол Улсад 1990 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
	Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 54/263 тогтоолоор баталж, 2002 оны 02 дугаар сарын 12-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	2002 оны 10 дугаар сарын 11-ний өдөр нэгдэн орох тухай хуулийг баталж, Монгол Улсад 2001 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
	Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 54/263 тогтоолоор баталж, 2002 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	2002 оны 10 дугаар сарын 11-ний өдөр нэгдэн орох тухай хуулийг баталж, Монгол Улсад 2013 оны 07 дугаар сарын 27-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.

	Хүүхдийн эрхийн тухай конвенцын мэдээлэл хүргүүлэх журмын тухай нэмэлт протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2011 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 66/138 тогтоолоор баталж, 2014 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр хүчин төгөлдөр болсон.	2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр соёрхон баталж, Монгол Улсад 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
7	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 61/106 тогтоолоор баталж, 2008 оны 05 дугаар сарын 03-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр соёрхон батлах тухай хуулийг баталж, Монгол Улсад 2009 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын нэмэлт протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 61/106 тогтоолоор баталж, 2008 оны 05 дугаар сарын 03-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр соёрхон батлах тухай хуулийг баталж, Монгол Улсад 2009 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
8	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 39/46 тогтоолоор баталж, 1987 оны 06 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	2001 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр нэгдэн орох тухай хуулийг баталж, Монгол Улсад 2002 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 57/119 тогтоолоор баталж, 2006 оны 06 дугаар сарын 22-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр соёрхон батлах тухай хуулийг баталж, Монгол Улсад 2015 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.
9	Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 61/177 тогтоолоор баталж, 2010 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	2014 оны 10 дугаар сарын 09-ний өдөр соёрхон батлах тухай хуулийг баталж, Монгол Улсад 2015 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Эдгээр хүний эрхийн суурь гэрээнээс гадна Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас баталсан Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай 87 дугаар конвенц, Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтээр алагчлахгүй байх тухай 111 дүгээр конвенц, Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенц гэх зэрэг нийт 21 гэрээ, конвенцод Монгол Улс нэгдэн орж, соёрхон баталжээ.

Монгол Улсын Их Хуралд хүний эрхийн асуудлыг дагнан эрхэлдэг Хүний эрхийн дэд хороо ажилладаг. Энэхүү дэд хороо нь Хууль зүйн байнгын хорооны дэргэд хүний эрх, эрх чөлөөний баталгаа, өршөөл, цагаачлал, иргэний харьяаллын асуудлыг хариуцан ажилладаг (*Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн §28.2.11*).

Хүний эрхийн дэд хороо нь парламентын хүний эрхийн хорооны нийтлэг жишгийн дагуу эрхлэх асуудлаа дагнан хариуцаж санал дүгнэлт гаргах, түүнийгээ Хууль зүйн байнгын хороонд, шаардлагатай бол Хууль зүйн байнгын хороогоор уламжлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, хариуцсан асуудлын хүрээндээ хянан шалгах үйл ажиллагаа явуулах чиг үүрэгтэй (*Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн §24.3*).

Мөн УИХ дахь бусад дэд хорооны нэгэн адил дараах бүрэн эрхтэй: хүний эрхийн, эсхүл эрхлэх бусад асуудлаар хяналт шалгалт, судалгаа хийх, холбогдох мэдээлэл авах, зохих албан тушаалтан, иргэн, байгууллагаас тайлбар авах, ажлын хэсэг байгуулах, эрхэлсэн асуудлаараа тогтоол гаргах, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулж харьяалах байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх зэрэг эрхтэй (*Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн §28.4*).¹¹⁰

Тус дэд хороо 2021 оны намрын ээлжит чуулганаас хойш өнөөдрийг хүртэлх ээлжит болон ээлжит бус 5 чуулганы хугацаанд 1 удаа хуралдсан байна. Тус 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. ...” гэж заасан эрхийн талаар болон Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх асуудлыг хэлэлцсэн бөгөөд хуралдаанд холбогдох хууль, хяналтын байгууллагын албан хаагчид,ТББ, иргэдийн төлөөлөл оролцжээ¹¹¹.

¹¹⁰ О.Мөнхсайхан, Р.Очирбал, “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл” (тойм судалгаа), Улаанбаатар хот, 2021 он. 439-442 дахь тал.

¹¹¹ УИХТГ, “Хүний эрхийн дэд хороо хүний эрхийн талаар болон Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн асуудлаар мэдээлэл сонслоо” веб мэдээ, Дэлгэрэнгүйг: <https://www.parliament.mn/nn/15266/> (Сүүлд нэвтэрсэн: 2023.11.03)

Дээр дурдсан олон улсын гэрээ, түүний Нэмэлт протоколын дагуу манай улсын зүгээс эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн зэрэг эрхээ зөрчүүлсэн тохиолдолд өөрөө болон итгэмжит төлөөлөгчөөрөө дамжуулан үндэсний болон олон улсын холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулсан (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт I протокол, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын нэмэлт протокол, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын нэмэлт протокол, Хүүхдийн эрхийн тухай конвенцын Мэдээлэл хүргүүлэх тухай нэмэлт III протокол), Эрүүгийн хуульд заасан ялын төрлөөс цаазаар авах ялыг 2015 онд халсан (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар Цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протокол), Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм 2022 оны 06 дугаар сард байгуулсан (Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протокол), мөн нээлттэй хяналт-шалгалт хийх журмыг (inquiry procedure) хүлээн зөвшөөрсөн билээ.

2.3. ХЭҮК байдаг уу? Хэрэв байдаг бол өнөөгийн байдлаар Парисын зарчмыг хэр хэмжээнд дагаж мөрдөж байгаа вэ?

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий Улсын Их Хурлаас байгуулагддаг, хараат бус, бие даасан үндэсний байгууллага юм.

Улсын Их Хурлаас 2000 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг баталж, Комиссын 3 гишүүнийг томилсноор үйл ажиллагаагаа эхэлжээ. НҮБ-аас 1993 онд баталсан Парисын зарчимд ХЭҮК-ын үйл ажиллагааг нийцүүлэх зорилгоор Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, тус Комиссын үндсэн бүрэлдэхүүнийг 6 гишүүнтэй болгож, хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрх, чиг үүргийг нь өргөжүүлсэн болно. Уг шинэчилсэн найруулгыг баталснаар ХЭҮК-ын хараат бус, төсвийн бие даасан байдлыг бататгаж, Комиссын гишүүдийг томилох үйл явцад шинэчлэл хийсэн. Мөн НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протоколоор хүлээсэн үүргийн дагуу Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий үндэсний механизмыг хариуцсан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг УИХ-аас 6 жилээр томилдог болсон. Тус гишүүн нь ХЭҮК-ын бусад гишүүнээс харьцангуй бие даасан статустай

бөгөөд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31-36 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Тэрбээр дэргэдээ түүнд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгжтэй байх ба Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд Хууль зүйн байнгын хороонд танилцуулж, хэвлэн нийтэлдэг.

Тус Комисс нь 2002 онд Ази, Номхон далайн бүс нутгийн Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Чуулганы бүрэн эрхт гишүүнээр, 2003 онд Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Дэлхийн Холбооны санал өгөх бүрэн эрхтэй гишүүнээр, 2018 онд Евразийн Омбудсмэний Холбооны гишүүнээр элссэн. Комисс нь НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл болон хүний эрхийн гэрээний хороодод хүний эрхийн асуудлаар хөндлөнгийн мэдээлэл хүргүүлэх, хуралд хараат бусаар оролцох эрхтэй.

Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Олон улсын зохицуулах хорооноос Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааг Парисын зарчимд нийцсэн хэмээн 2003, 2008, 2014, 2021 онуудад “А” статусаар магадлан итгэмжилсэн юм. Ийнхүү магадлан итгэмжилсэн ч тус зохицуулах хорооны Магадлан итгэмжлэх дэд хорооны зүгээс Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Парисын зарчмыг бүрэн биелүүлэх тухай зөвлөмж, үнэлгээ өгч байгааг заавал харгалзан үзэж, хэрэгжүүлбэл зохино.¹¹² Ялангуяа магадлан итгэмжлэх бүрд өөрийн ажлын байргүй¹¹³, хангалттай төсөв хуваарилаагүй, нэр дэвшүүлэх, томилох үйл явц ил тод, нээлттэй бус байхын¹¹⁴ зэрэгцээ 2021 онд Иргэний нийгмийн зөвлөлдөө нийгмийн олон янз байдал, олон талт төлөөлөл хангах, өөрийн алба хаагчдаа шууд ажилд авдаг байх талаар Магадлан итгэмжлэх дэд хороо тайландаа зөвлөжээ.¹¹⁵

Улсын Их Хурал 2001 оноос хойш төсвийг өсөн нэмэгдүүлэх байдлаар хуваарилж байсан ч Хүний эрхийн Үндэсний Комиссын төсөв 2009, 2015, 2016 онд буурч, үйл ажиллагааны зардлыг Сангийн яамны саналаар танаж байсан болно. Энэхүү туршлагыг халах үүднээс Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль шинэчлэн найруулахдаа “Комиссын дарга Байнгын хороогоор зөвшөөрөгдсөн төсвийн төслийг улсын нэгдсэн төсвийн төсөлд нэгтгүүлэхээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлнэ” гэж зааснаар Хууль зүйн байнгын хорооны оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлжээ. Уг комиссын гишүүдийг томилохдоо Хууль зүйн байнгын хороо томилгооны сонсгол

¹¹² Б.Болорсайхан, “Хүний эрхийн үндэсний байгууллагыг үнэлэх нь” нийтлэл, “Хүний эрх” онол арга зүйн сэтгүүл (2014/02), Улаанбаатар хот, 2014 он. 28 дахь тал.

¹¹³ Засгийн газрын байранд ажлын байраа одоо хүртэл түрээслэн байрладаг.

¹¹⁴ Б.Болорсайхан, “Хүний эрхийн үндэсний байгууллагыг магадлан итгэмжлэх үйл явцад Монгол Улс” нийтлэл, “Хүний эрх” онол арга зүйн сэтгүүл (2015/02), Улаанбаатар хот, 2015 он. 29-35 дахь тал.

¹¹⁵ Магадлан итгэмжлэх дэд хороо, Цахим хуралдааны тайлан, зөвлөмж, 2021 оны 10 дугаар сарын 18-29 -ний өдрийн хуралдаан. 12-15 дахь тал. Дэлгэрэнгүйг: https://ganhri.org/wp-content/uploads/2021/12/SCA-Report-October-2021_EN.pdf (Сүүлд нэвтэрсэн: 2023.11.04)

зохион байгуулахаар хариуцуулсан нь дэвшилтэт алхам байсан (*Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн §32.3*).

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс 2015-2018 онд Ази, Номхон Далайн бүс нутгийн Хүний эрхийн байгууллагын Чуулганыг даргалж, 2022 оноос Ази, Номхон Далайн бүс нутгийн Хүний эрхийн байгууллагын Чуулганы дэд даргаар сонгогдон ажиллаж байна. Түүнчлэн Хүний эрхийн Үндэсний Комиссоос Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т “хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал гаргах” чиг үүргийнхээ хүрээнд хууль тогтоомж, захиргааны акт, төрийн болон төрийн бусад байгууллагаас гаргасан шийдвэр хүний эрхийн зарчимд нийцэж буй эсэхэд тодорхой саналуудыг өгч ажиллаж байна.¹¹⁶

2.4. Улс орны эрх зүйн тогтолцоо, үндэсний бодлого болон үйл ажиллагаа нь ардчилсан орон зайг хэр зэрэг хамгаалж, иргэний нийгмийг үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх боломжоор хангадаг вэ?

Монгол Улсын Үндсэн хуулийн оршилд “Монголын ард түмэн бид: ... эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.” хэмээн зарлан тунхагласан. Мөн Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасан нь ардчилал, ардчилсан ёс нь Монголын нийгмийн тулгуур үнэт зүйлийн нэг мөн болохыг бататгасан хэрэг юм. Түүнчлэн “Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа” болно гэж Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.4-т тусгажээ.

Манай улсын Үндсэн Хуульд заасны дагуу төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээдэг. Улсын Их Хурлаас 2003 онд баталсан “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-т төрөөс тэрхүү үүргээ үр дүнтэй гүйцэтгэж, хүний эрхийн баталгааг хангалттай бүрдүүлэхийн тулд Хүний эрхийг хангах үндэсний механизм (тогтолцоо)-ыг бүрдүүлж, тус механизмын бүрдэл хэсгийн чадавх, хүний эрхийг сахин биелүүлэх, бэхжүүлэх, хамгаалах, хангах үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх арга зам, үүрэг хариуцлагыг тодорхойлсон.

¹¹⁶ Хүний эрхийн Үндэсний Комисс, Танилцуулга. Дэлгэрэнгүйг: <https://nhrcm.gov.mn/> (Сүүлд нэвтэрсэн: 2023.11.03)

Хүний эрхийг хангах үндэсний механизм дараах бүрдэл хэсэгтэй. Үүнд:

- хууль тогтоох болон бүх шатны гүйцэтгэх байгууллага;
- Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүх, прокурор, өмгөөлөх гэх мэт хүний эрхийг хангах шууд үүрэг зорилго бүхий төрөлжсөн байгууллагууд;
- нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг оролцуулан иргэний нийгмийн бүх байгууллага, хөдөлгөөн, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл;
- бүх төрлийн бизнес эрхлэгч хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаа;
- хүний эрхийг хангах, хамгаалах ажлын алба, тэдгээртэй адилтгах дотоодын хэрэглүүрүүд.

Хожим Монгол Улс дахь хүний эрхийг хамгаалах энэхүү үндэсний тогтолцоо (механизм)-г Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиар баталгаажуулан нарийвчлан хуульчилсан билээ. Тодруулбал, 2020 оны 01 дүгээр сард баталсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар анх удаа хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоонд төр эн тэргүүнд үүрэг хүлээж, иргэний нийгмийг татан оролцуулан ажиллах хууль зүйн баталгааг хангасан билээ.

Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, боловсронгуй болгох ажлын хүрээнд хамгийн сүүлд 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай” хуулийг хэлэлцэн батлав. Энэхүү хуульд “хүний эрхийн хамгаалагч” гэж хэн болох, “хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаа” гэж юу болох, “хүний эрх хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах”, “хүний эрхийн хамгаалагчийн эрхэд халдах” зэрэг ойлголтыг тодруулан томъёолсны зэрэгцээ хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай эрхийг улам өргөжүүлж, тусгайлан баталгаажуулж, үйл ажиллагаа явуулахдаа хориглох зүйл, мөн хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны санхүүгийн ил тод, нээлттэй байдлын талаар; төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн зүгээс хүний эрх хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, тэдний үйл ажиллагааг дэмжих, хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн тохиолдолд хуулиар хариуцсан чиг үүргийн хүрээнд шуурхай арга хэмжээ авч ажиллах, байгууллагынхаа дотоод журамд хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг тусгах тодорхой үүрэг хүлээхээр зааж өгсөн. Түүнчлэн Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороог ХЭҮК-ын эргэд байгуулж, хорооны бүрэлдэхүүнд ажиллах иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлд тодорхой шалгуур тавьсан нь иргэний нийгмийг чадавхжуулах, дэмжих зорилготой бөгөөд хамтын шийдвэрээр анх удаа нэр дэвшүүлж, нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгох зэрэг олон шинэлэг зохицуулалтыг тусгасан байна.

Энэ хууль батлагдсанаар Монгол Улс хүний эрхийн асуудал, зөрчлийн талаар тэмцэж байгаа хүмүүсийг хамгаалах тогтолцоог бүрдүүлсэн Азийн анхны улс болсон байна.¹¹⁷

1992 оны ардчилсан, шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Монгол Улсад ардчилал, хүний эрх, эрх чөлөөг хангах чиглэлээр томоохон ахиц дэвшил, ололт, амжилтууд гаргасан хэдий ч цаашид засаж залруулах, сайжруулах, төгөлдөршүүлэх олон тулгамдсан асуудал, сорилт, бэрхшээлүүд байсаар байна.

Монгол Улс Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексээр 2021 онд 68 дугаар байрт байсан бол 2022 онд 180 улсаас 90 дүгээрт орж 20 орчим байраар ухарсан. Мөн ардчиллын индексээр 2022 онд 6.35 оноо авч, “Сул ардчилалтай” улс орны ангилалд орж байна.

Төрийн бус байгууллагын тухай 1997 оны хууль нь иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулахад чухал алхам болсон хэдий ч төрийн бус байгууллагын тогтвортой, үр нөлөөтэй хөгжлийг дэмжих болон ашгийн төлөө бус, нийтэд тустай үйл ажиллагааг оновчтой зохицуулах хэрэгцээ шаардлага тулгамдаж байна. Монгол Улсад ИНБ-ын тоо жилээс жилд хурдацтай өсөж 1998 онд 1075 ТББ бүртгэлтэй байсан бол 2005 онд 3492, 2010 онд 6915, 2015 онд 11.879, 2017 оны 04 дүгээр сарын байдлаар 17.685, 2018 оны 06 дугаар сарын байдлаар нийт 17.634 болсон бол 2022 оны байдлаар 25.000 хүрсэн байна.

Монгол Улсад бүртгэлтэй ТББ-ын дийлэнх нь төрд тавих иргэдийн хяналтыг сайжруулах буюу нийгэмд үйлчлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ чиглэлийн ТББ-ын тоо сүүлийн 5 жилд 2.2 дахин өсжээ. ТББ-ыг үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, 72.8 хувь нь үйлчилгээний салбарт, 11.7 хувь нь боловсрол, 5.8 хувь нь мэдээлэл, холбоо, 3.7 хувь нь урлаг, үзвэр, тоглоом наадам, 2.3 хувь нь мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, үлдэх 3.7 хувь нь бусад салбарт бүртгэлтэй байна.¹¹⁸

Иргэний нийгмийн байгууллагууд, түүний үйл ажиллагаа нь хууль тогтоох үйл ажиллагааны бүхий л үе шат болон хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулж байна. Мөн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”-д иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх талаар тусгаж, хэрэгжүүлж байна.

¹¹⁷ УИХ-ын 2021 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны танилцуулга (2021.03.15-2021.07.08)-ын 122 дахь тал

¹¹⁸ Конрад-Адэнауэр-Сан, МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхим, “Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа” Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж, Улаанбаатар хот, 2020. 221 дэх тал

Мөн иргэний нийгмийн үйл ажиллагааг зохицуулж буй гол хуулиудаас гадна Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай (1991), Төр, сүм хийдийн харилцааны тухай (1993), Жагсаал, цуглаан хийх журмын тухай (1994), Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай (1997), Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай (2021) зэрэг хуулиуд нь иргэний, ардчилсан орон зайг тэлэх хамгаалалт, баталгаа болж байна.

Сүүлд хийгдсэн 2019, 2022 оны Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь парламентат ёсыг хөгжүүлэх, бэхжүүлэхэд чиглэсэн маш том шинэчлэл болсон. Энэ хүрээнд хүний эрх, иргэдийн оролцоог хангахад чиглэгдсэн олон хууль тогтоомжуудыг шинэчлэн баталсан. Жишээлбэл, Төрийн өндөр албан тушаалтнуудын томилгооны сонсгол хийх, улс төрийн намыг бодлогын нам болгон төлөвшүүлэх, намын дотоод ардчиллыг бэхжүүлэх, санхүүжилтийг ил тод, боловсронгуй болгох зэрэг зохицуулалтуудыг оруулсан.

Түүнчлэн Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн нэг дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэсэн заалтыг амьдралд бодитоор хэрэгжүүлэх “Парламентын боловсрол”, D-Parliament, D-Petition хөтөлбөрүүдийг Парламентын удирдлагын зүгээс санаачлан хэрэгжүүлсэн нь амжилттай нэвтэрч, тодорхой ахиц дэвшил үзүүлж байна. Мөн УИХ-ын гишүүдийн тоог нэмэгдүүлж 126 болгон сонгуулийн холимог тогтолцоог хуульчилснаар Парламент дахь нийгмийн тодорхой бүлгүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд зохих хувь нэмэр үзүүлэх нь дамжиггүй. Дашрамд дурдахад Үндсэн хуулийн эдгээр нэмэлт, өөрчлөлтийг хийхдээ зөвлөлдөх ардчиллын нэг хэлбэр болох зөвлөлдөх санал асуулгаар ард нийтийн санаа бодлыг тусган, тэдний оролцоог хангасан.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж буй байдал:

2000 оны 12 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт “Комисс нь үйл ажиллагаагаа явуулахад туслах үүрэг бүхий өмгөөлөгчдийн холбоо, үйлдвэрчний эвлэлийн холбоо, хүний эрхийн асуудал эрхэлсэн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан орон тооны бус зөвлөл байгуулж болно” гэж заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2002 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 6 дугаар тушаалаар анхны орон тооны бус зөвлөлийг 11 гишүүний бүрэлдэхүүнтэй 3 жилийн хугацаатайгаар байгуулсан бөгөөд 2014 оноос эхлэн Иргэний нийгмийн зөвлөл нэрээр 7 дахь бүрэлдэхүүн үйл ажиллагаагаа явуулж байна.

2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт “Комисс үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий иргэний нийгмийн зөвлөлтэй байна” гэж заасны дагуу Комиссын даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар “Иргэний нийгмийн зөвлөлийн дүрэм”-ийг баталж 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/16 тушаалаар Иргэний нийгмийн зөвлөл 18 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус Комисс 2011-2021 онд 58 судалгааны ажил хийснээс 15 судалгааг иргэний нийгмийн байгууллагатай хамтран хийсэн байна. Тухайлбал: Шашны сургууль, сүм хийдэд шавилан суралцаж буй хүүхдийн эрхийн нөхцөл байдалд хийсэн хяналт, үнэлгээний ажлыг НҮБ-ын Хүүхдийн сан, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ, “Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал: Худалдаа үйлчилгээ, ноос ноолуурын салбар” судалгааны ажлыг ОУХБ, Европын холбоо, “Карьер хөгжлийн хүрээлэн” ТББ-тай тус тус гүйцэтгэсэн байна.¹¹⁹

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд, хүний эрхийн төрийн бус байгууллагуудын төлөөлөл бүхий Хүний эрхийг хангах Үндэсний хороо 2023 онд Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг илтгэх, тайлагнах журам баталж, өнгөрөгч оны буюу 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хугацаанд орон нутагт хүний эрхийн төлөв байдал ямар байгааг Засаг дарга нараар тайлагнуулж, илгээсэн тайланг олон талын төлөөлөлтэй хэлэлцжээ.¹²⁰ Энэхүү шинэ тутам илтгэх, тайлагнах механизм нь Хүний эрхийн Үндэсний Комисс, мэргэжлийн холбоод, хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, шинжээч, судлаач бүтээлчээр хамтран оролцох иргэний шинэ орон зай болж байна.

2.5. Парламент аливаа ялгаварлан гадуурхалд хамгийн их өртөж болзошгүй тодорхой бүлгүүдийн талаар болон эрх тэгш байдал, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хамгаалахтай холбоотой Системийн сорилтуудын талаар мэддэг үү?

Аливаа ялгаварлан гадуурхалд хамгийн их өртөж болзошгүй тодорхой бүлгийн эрхэд хүүхдийн эрх, ахмад настны эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, үндэсний цөөнхийн эрх, жендэрийн эрх болон бэлгийн цөөнхийн эрхүүд хамаардаг. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, Хүний эрхийн

¹¹⁹ Хүний эрхийн Үндэсний Комисс, Танилцуулга. Дэлгэрэнгүйг: <https://nhrcm.gov.mn/> (Сүүлд нэвтэрсэн: 2023.11.03)

¹²⁰ ЗГХЭГ, “Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлын тайланг илтгэж эхэллээ” мэдээ. Дэлгэрэнгүйг: <https://cabinet.gov.mn/8984.html>

дээд комиссарын газарт Монгол Улсаас хүргүүлдэг хүний эрхийн суурь гэрээний хэрэгжилтийн талаарх дүгнэлт зөвлөмж, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR)-т дурдсан бүлгийн эрхийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал, бэрхшээл, шийдлийн талаар санал, зөвлөмж гаргаж, тэдгээрээс тодорхой зарим асуудлыг парламентын түвшинд шийдвэрлэж ирсэн болно. Тухайлбал, сүүлийн жилүүдэд УИХ-аас авч хэрэгжүүлсэн дараах арга хэмжээг дурдаж болно. Үүнд:

1. Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын суурь стандарт Монгол Улсад үйлчилдэг. Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцыг, 2003 онд Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн конвенцын нэмэлт протоколыг, 2004 онд Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн конвенцын 2 дугаар протоколыг, 2015 онд Мэдээлэл хүргүүлэх журмын тухай Хүүхдийн эрхийн конвенцын 3 дугаар нэмэлт протоколыг тус тус соёрхон баталсан. Түүнчлэн 2001 онд Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай 182-р конвенц, 2002 онд Хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарын тухай 138-р конвенцыг мөн соёрхон баталжээ.

Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн үндэсний хууль тогтоомжийг шинэчлэх, боловсронгуй болгох ажлын хүрээнд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудыг 2016 онд шинэчлэн найруулж баталсан бөгөөд эрүү, иргэн, зөрчлийн, боловсролын гэх зэрэг салбарын болон салбар дундын зохицуулалтай 20 шахам хуулиар хүүхдийн эрхийг хангахтай холбоотой энэхүү харилцааг зохицуулж байна. Мөн тухайн асуудлаар Засгийн газар, асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан 30 гаруй дүрэм, журам, стандарт мөрдөгдөж байна. Түүнчлэн Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичиг үндэсний хэмжээнд хэрэгжиж байна.

Хүүхдийн эрхийг хангах олон улсын болон үндэсний тогтолцооны хүрээний бодлого, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласны үр дүнд Монгол Улсад тус чиглэлд гарсан ахиц дэвшлийг ерөнхийлөн тоймловол:

- Хүүхдийн эрх хамгааллын чиглэлээрх олон улсын гэрээ, конвенцуудад нэгдэн орж соёрхон баталсан;
- Хүүхдийн эрх хамгааллын эрх зүйн орчныг хангалттай хэмжээнд бүрдүүлсэн;
- Хүүхдийн эрхийг хамгаалах үндэсний тогтолцооны байгууллага, институцүүд байгуулагдсан;
- Хүүхэд, гэр бүлийг хамгаалах чиглэлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөөнүүдийг зохих түвшинд боловсруулан баталсан;

- Энэ чиглэлийн олон улсын байгууллага, төр, иргэний нийгмийн байгууллагуудаас олон тооны суурь болон бусад судалгаа, үнэлгээ хийгдэж, олон төрлийн төсөл, арга хэмжээнүүд хэрэгжиж байна.

Хэдий тийм боловч хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, төсөв, санхүүгийн хомсдол, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, чадавх сул, олон улсын байгууллага, хандивлагчийн зүгээс тулгамдсан асуудал, хэрэгцээнээс илүүтэй өөрийн хөтөлбөр, санаачилгыг тулгах, хөгжлийн байгууллагын зүгээс эрхэд суурилсан бус хэрэгцээнд суурилсан хандлагыг удирдлага болгон ажиллах, мөн хүүхдийн эрхэм чанар, эрх, эрх чөлөө, дээд ашиг сонирхлыг хүндэтгэх талаарх нийгмийн сэтгэл зүй, хандлага дулимаг, ядуурал, ажилгүйдэл гэх зэрэг улс төр, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлээс шалтгаалан хүүхдийн эрхийн ноцтой зөрчил, дутагдал арилахгүй байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тавдугаар тайлан илтгэлийг хэлэлцээд тодорхой чиглэлд төрөлжүүлэн нэгтгэсэн зөвлөмж ирүүлсэн нь цаашид энэ чиглэлээр анхаарах шаардлагатай үндсэн асуудал болно.¹²¹ Хүний эрхийн Үндэсний Комисс анх 2005 онд Эрүүдэн шүүхийн эсрэг үндэсний хяналт-шалгалт (national inquiry) хийж байсан туршлагадаа тулгуурлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын хамтарсан 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн “Нээлттэй хяналт-шалгалт хийх тухай” А/34,12 дугаар тушаал, хоёрдугаар хавсралтаар удирдамж баталж, мэдээлэл цуглуулах ажлыг 2023 оны 03 дугаар сарын 27-оос 04 дүгээр сарын 25-ны хугацаанд зохион байгуулжээ. Одоогийн хүүхэд хамгааллын тогтолцоонд оролцогч төрийн байгууллагуудыг татан оролцуулахын зэрэгцээ хүүхдийн эрхийн тодорхой чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий ажлын хэсгийн гишүүд болон аймаг, дүүргийн Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Хүний эрхийн Үндэсний Комиссын ажилтнууд хамтран ажиллажээ. Энэхүү Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд хийсэн нээлттэй хяналт шалгалт нь 17 жилийн дараах үндэсний хяналт-шалгалт бөгөөд цаашид хүүхдийн эрхийн баталгааг хэрхэн хангах талаар тухайлан дүгнэлт, зөвлөмж боловсруулсан юм.¹²²

Хүүхдийн эрхийн зөрчлийг арилгах талаарх шаардлага, дээр дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын

¹²¹ О.Мөнхсайхан, Р.Очирбал, “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл” (тойм судалгаа), Улаанбаатар хот, 2021 он. 355 дахь тал.

¹²² Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд нээлттэй хяналт шалгалт хийсэн тайлан, дүгнэлт, зөвлөмж. дэлгэрэнгүйг: <https://irgen-tur.mn/mn/blog/ogp/single/209> (Сүүлд нэвтэрсэн: 2023.11.04)

хорооноос 2023.07.05-нд Хүүхдийн эрхийн тухай хуульд заасан хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол хийсэн. Улмаар 2023.10.06-нд УИХ-ын чуулганы хуралдаанаар Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаарх мэдээллийг сонсож, хүүхдийн эрхийн нээлттэй сонсгол хийхийг холбогдох байнгын хороонд даалгасны дагуу Хууль зүйн байнгын хорооноос 2023.10.25-нд Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар хяналтын сонсгол зохион байгуулав.

2. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 22 дахь илтгэлийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2.3-т заасны дагуу 2023 оны 04 дүгээр сарын 25, 26-ны өдрүүдэд, хоёр өдрийн турш олон нийтэд нээлттэй, ил тод, сэдэв тус бүрээр хэлэлцсэн билээ.

Илтгэлд ахмад настны ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс ангид байх эрхийн зохицуулалт, нөхцөл байдал, шийдвэрлэх арга замын талаар дурджээ.

Судалгаануудаас үзэхэд ахмад настнууд хүчирхийллийн бүхий л хэлбэрт өртөж байх бөгөөд энэ нь дан ганц хүчирхийллийн нэг хэлбэрээр хязгаарлахгүй байна. Ялангуяа эдийн засагт суурилсан сэтгэл санааны болон бие махбодын хүчирхийлэл, үр хүүхэд, ойрын хамаарал бүхий хүмүүсийн зүгээс үл хайхрагдах хүчирхийлэлд өртөх нь түгээмэл бөгөөд хүчирхийллийг гол төлөв эхнэр, нөхөр, хүү, охин зэрэг ойрын хүмүүсийн зүгээс үйлддэг байна. Гэвч гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн ахмадууд холбогдох байгууллагад төдийлөн мэдээлдэггүй байна. ХЭҮК-ын судалгаанд оролцогч ахмадуудын зөвхөн 15 хувь нь цагдаа, хороо, хэсгийн ахлагч, нийгмийн ажилтанд мэдэгдсэн бол 85 хувь мэдээлээгүй гэж хариулжээ. Мэдэгдээгүй шалтгаанаа хаана хандахаа мэдэхгүй, үр хүүхдийнхээ нэр төрийг бодсон, дарамт шахалтаас айсан, хандаад нэмэргүй байсан, өвчтэй, хэвтэрт, гарах боломжгүй гэж тайлбарлажээ. УИХ-аас тус илтгэлийн дээрх нөхцөл байдлыг хэлэлцээд 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар тогтоол баталж, Ахмад настны эрхийн хэрэгжилтийн талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгажээ. Үүнд:

а/ ахмад настны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлэх зорилтыг эрчимжүүлэх, насжилтын үеийн өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг хүчин зүйлсийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

б/ ахмад настныг ажлын байраар хангаж байгаа ажил олгогч, аж ахуйн нэгжүүдийг татварын болон бусад бодлогоор дэмжих;

в/ ахмадын асрамж, хамгаалал, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөлийг бий болгох асуудлаар цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.

Мөн УИХ үндэсний цөөнх, бэлгийн цөөнхийн асуудлаар ХЭҮК-ын илтгэлд дурдсан асуудлаар арга хэмжээ авах талаар тогтоолууд гаргаж байв.

Сүүлийн 12 сарын хугацаанд:

Парламент хүний эрхийн талаар тодорхой зохицуулалт бүхий хууль тогтоомж батлах буюу нэмэлт, өөрчлөлт оруулсан эсэх, мөн бүс нутгийн/ олон улсын хүний эрхийн гэрээг баталсан уу? Хэрэв ийм хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бол эдгээр нэмэлт, өөрчлөлт нь батлагдсан уу?

УИХ-аас батлан гаргаж буй бүх хууль тогтоомж нь ямар нэг хэмжээгээр хүний эрхийг хангаж, хамгаалах чиг үүргийг агуулж байдаг. Тухайлбал:

Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай конвенц зэрэг олон баримт бичгээр хамгаалсан сурч боловсрох эрхийг хангаж, баталгаажуулсан Боловсролын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга)-ийг УИХ 2023.07.07-ны өдөр хэлэлцэн баталсан. Энэ нь сүүлийн 12 сарын хугацаанд батлан гаргасан хуулиудаас хүний эрхийн талаар тодорхой зохицуулалт бүхий суурь хуулийн нэг жишээ юм. Тус хуулиар боловсролын тогтолцоог шинэчилж, боловсролыг заавал танхимд суун эзэмшиж байгааг өөрчилж, албан, албан бус болон амьдралын орчинд суралцахуйн тогтолцоотой байхаар хуульчилсан. Энэ хүрээнд хүний амьдралын орчинд суралцахуйн замаар эзэмшсэн боловсролыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, мөн боловсролыг танхимын, танхимын бус, эдгээрийн хосолсон хэлбэрээр эзэмших боломж бүрдсэн. Мөн багшийн хөгжлийн тасралтгүй үйл ажиллагаа, чанар, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, сургалтын хөтөлбөр агуулгын талаар зохицуулсан төдийгүй сургалтын үндсэн гадаад хэл нь англи хэл байх бөгөөд суралцагчийн эх хэлээрээ суралцах болон бусад гадаад хэл суралцах эрхийг үл хөндөнө хэмээн заасан. Тус хуульд тусгагдсан хүний эрх, хүний эрхийн боловсролын суурь үзэл баримтлалын шинжтэй онцлох заалтуудаас дурдвал:

Боловсролын зарчмыг тодорхойлсон 5 дугаар зүйлд “тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байх; хүний эрх, эрх чөлөө, төрт ёс, түүх, соёлын уламжлал, үнэт зүйлсийг нандигнан өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахисан байх.” гэж тусгасан. Суралцагч нь

“бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, ялгаварлан гадуурхах, дарамтлах, доромжлох, нэр төр, алдар хүндийг нь гутаах үйлдэл гаргахгүй байх” үүрэгтэй (*Боловсролын ерөнхий хууль, §10.2.6*). Мөн “хүний эрхийн боловсрол, жендэрийн эрх тэгш байдал”-ыг бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт заавал тусгаж, боловсролын сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлнэ (*Боловсролын ерөнхий хууль, §14.4.3*.) хэмээн тус тус заажээ.

Дурдсан хугацаанд УИХ-аас хүний эрхэд шууд холбогдолтой 1 илтгэл, 1 тайланг хэлэлцэж, 1 тогтоол гаргав. Мөн 5 хуулийн төсөл хэлэлцүүлгийн шатанд байна. Үүнд:

1. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоол (2023.05.04-ний өдөр) баталсан;
2. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль (Шинэчилсэн найруулга), Гэр бүлийн тухай хууль (Шинэчилсэн найруулга), Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль зэрэг хуулийн төслүүдийг өргөн мэдүүлсэн, хэлэлцүүлгийн шатанд байна.

Хүний эрхийн тухай гэрээ, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталсан уу?

Сүүлийн 12 сард Монгол Улсын Их Хурал болон Засгийн газар Хүний эрхийн талаарх олон улсын аливаа нэг гэрээ, конвенц, протоколд нэгдэн ороогүй байна. (асуулт 2.2-ыг үзнэ үү)

Парламент эмзэг бүлгийн иргэдийн эрхийн хамгаалалтыг сайжруулах зорилготой хууль тогтоомжид үнэлгээ хийх, эсхүл баталсан уу?

УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооноос 2023.07.05-ны өдөр Хүүхдийн эрхийн тухай хуульд заасан хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол хийсэн. Улмаар 2023.10.06-ны өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаарх мэдээллийг сонсож, хүүхдийн эрхийн нээлттэй сонсгол хийхийг холбогдох Байнгын хороонд даалгасны дагуу Хууль зүйн байнгын хорооноос 2023.10.25-ны өдөр Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар хяналтын сонсгол зохион байгуулав.

АСУУЛТ 3. ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТЫГ БЭХЖҮҮЛЭХ

Сэдвийн тойм

1992 оны ардчилсан, шинэ Үндсэн хууль, түүнд оруулсан 2019, 2023 оны нэмэлт, өөрчлөлтүүд нь Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг хангах, парламентад ёсыг төлөвшүүлэх, бэхжүүлэхэд чиглэгдэж байсан. Ялангуяа 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хууль тогтоох байгууллагын үндсэн чиг үүргийн нэг болох хуулийн биелэлтэд хяналт тавих бүрэн эрхийн хүрээ, хязгаарыг өргөжүүлж тодорхойлсон. Энэ хүрээнд 2021 онд УИХ-аас парламентын хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг батлан гаргасан.

Үндсэн хуульд заасан ёсоор төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээсэн байдаг. Төрийн зүгээс энэхүү үүргээ хэрэгжүүлэхийн тулд урт болон дунд хугацааны бодлогын баримт бичиг, зорилтот хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж ирснээс хамгийн чухал, тулгуур баримт бичиг нь УИХ-аас 2003 онд баталсан “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр” юм. Бодлогын баримт бичгүүд нь хүний эрхийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан байдгаараа Парламентаас тухайн тодорхой эрхийг хангах, хамгаалах арга хэмжээний биелэлт, хэрэгжилтийг нь үнэлж дүгнэх, хянах боломжийг олгож байдаг. Энэ утгаараа уг хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж дүгнэх, шинэчлэх, хэрэгжилтийг сайтар хангах шаардлага бий.

УИХ хяналтын чиг үүргээ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан 7 арга хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлдэг. Тэдгээр арга хэрэгслүүд нь Засгийн газрын бодлого, шийдвэр, үйл ажиллагаа хүний эрх, эрх чөлөөг хангаж буй эсэхэд хяналт тавихад чиглэгдсэн ба асуулт, асуулга тавих, тайлан илтгэл, мэдээлэл хэлэлцэх, хүний эрхийг хангахтай холбоотой хяналтын сонсгол хийх зэрэг олон төрлийн хяналтын механизмуудыг багтааж байдаг.

Парламентын түвшинд Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт болон өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Хүний эрхийн олон улсын конвенцууд, НҮБ-аас хүний эрхийн талаар гаргасан зөвлөмжүүдэд нийцэж буй эсэхэд тус тус нөлөөллийн үнэлгээ хийж хэвших зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд УИХ-ын Тамгын газрын ХЭЗГ-ын бүтцэд Эрх зүйн

дүн шинжилгээний хэлтэс, Мөн ХШҮГ-ын бүтцэд Төсвийн шинжилгээний хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээний алба байгуулагдсан бөгөөд эдгээр нэгжүүд нь УИХ-д өргөн барьсан хуулийн төсөл болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэгтэй ажиллаж байна.

3.1. Танай улсад хүний эрхийн үндэсний хэмжээний хөтөлбөр, стратеги байгаа юу?

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Тус хөтөлбөр нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулахад түлхэц болсон, бодлогын чухал баримт бичиг болсон юм.

Хөтөлбөрийн 4-р бүлэгт хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн асуудлыг тусгасан бөгөөд хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий Үндэсний хөтөлбөрийн хороо, түүний Ажлын алба 2006 оноос ажиллаж эхэлсэн билээ. Энэхүү ажлын алба нь Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэд ажиллаж байсан боловч уг алба татан буугдсанаар хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах үйл ажиллагаа нэг хэсэг зогсонги байдалд орсон юм. Тиймээс 2022 оны 09 дүгээр сард Хүний эрхийг хангах Үндэсний хороог байгуулж, Ажлын албыг ЗГХЭГ-ын дэргэд байгуулсан болно. Тус хөтөлбөр хэрэгжээд 20 жил болж буй ч үндсэндээ 10 гаруй жилийн хугацаанд хэрэгжилтийг хариуцах бүтэц алдагдаж, зохион байгуулалтгүй явж ирсэн нь хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байх үндэс болжээ.

Энэ хугацаанд хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ, түргэвчилсэн үнэлгээг тус бүр нэг удаа хийжээ. Анх 2011 онд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээг үндэсний хэмжээнд өргөн далайцтай хийсэн боловч зорилт тус бүрийн хэрэгжилтийн мэдээллийг харах боломжгүй байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтийг цогцоор нь үнэлсэн гэж үзэх боломжгүй байна. Хэдийгээр зорилт тус бүрийн хүрэх түвшин, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт боловсруулсан, үндэсний хөтөлбөр батлахаас өмнөх болон хэрэгжилтийн эхний шатны нөхцөл, өнөөгийн хүрсэн түвшнийг харьцуулсан талаар арга зүй, мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн тайлбарт бичсэн ч тайланд энэ мэдээлэл тусаагүй. Тайлангаас Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 2-р бүлгийн гурван дэд хэсэг, 3-р бүлгийн зорилт тус бүрийн хэрэгжилтийн түвшинг харах боломжгүй бөгөөд энэ нь нийт 146 зорилт буюу нийт зорилтын 60 хувь юм. 2011 оны байдлаар 243 зорилтоос бүрэн хэрэгжсэн 7, хэрэгжилтийн шатанд тодорхой үр дүн гарсан 144, хэрэгжиж эхэлж байгаа 36, ямар нэгэн арга хэмжээ аваагүй 56 зорилт байжээ.¹²³

¹²³ Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийн хороо, НҮБХХ "Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц" хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, Улаанбаатар хот, 2011 он.

Хожим Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар (2022.09.06, №44) “Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах Ажлын хэсэг” хүний эрхийн шинжээч, судлаачийн бүрэлдэхүүнтэй байгуулж, Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг удаан хугацаанд хэрэгжих төлөвлөгөө хэлбэрээр боловсруулах санал гаргажээ. Үүнтэй зэрэгцэн 2022 оны 04-10 дугаар сард Стратеги Академи ТББ-ын зүгээс Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр хэрэгжсэн талаарх түргэвчилсэн үнэлгээ хийж, 2022 оны хагас жилийн байдлаар 243 зорилтоос хэрэгжсэн 26, хэрэгжилт ахицтай 63, хэрэгжилт удаашралтай 83, хэрэгжилт муу 71 хэмээн үнэлсэн байна.¹²⁴

Үүнтэй уялдан Хүний эрхийг хангах Үндэсний Хорооны санаачилга, шийдвэрийн дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын манлайлал дор Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийн төслийг шинэчлэн боловсруулж УИХ-д хүргүүлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн “Алсын хараа - 2050”, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд хүний эрхийг хангах, хамгаалах бодлого, зорилтуудыг тусган хэрэгжүүлж байна. Тухайлбал: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа - 2050”-ын 5.5 дахь зорилт “Хүний эрхийг дээдэлсэн нийгэм” хэсэгт “Иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоог бүрдүүлнэ.” хэмээн зорилгоо тодорхойлж, энэхүү зорилгоо 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд: I үе шат (2021-2030): Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлэх үе; II үе шат (2031-2040): Хүний эрхийг хангах бодлого, хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт хүргэх үе; III үе шат (2041-2050): Нийгмийн бүх харилцаанд хүний эрхийг бүрэн хангасан тогтолцоог төлөвшүүлэх үе.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын дараах зорилтот хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлнэ. Үүнд:

¹²⁴ Стратеги Академи, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр хэрэгжсэн талаарх түргэн үнэлгээ, Улаанбаатар хот, 2022 он.

- 1.хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 2.нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 3.эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 4.байгаль орчны зорилтот хөтөлбөр;
- 5.засаглалын зорилтот хөтөлбөр;
- 6.бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 7.үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр.

Эдгээр зорилтот хөтөлбөр тус бүр нь Хүний тухайлсан эрхийг хангах, хамгаалах чиглэлээр нарийвчилсан тодорхой бодлого, зорилт дэвшүүлэх, үр нөлөө үзүүлэх боломжтой. Ялангуяа хүний хөгжлийн болон засаглалын зорилтот хөтөлбөрүүд нь хүний эрхийг хангах, хамгаалахтай шууд холбогдолтой бөгөөд Засгийн газраас эдгээр хөгжлийн 6 зорилтот хөтөлбөрийн хүрээнд 28 зорилго, 95 зорилт, 374 үйл ажиллагааг томьёолон тусгасан төслийг 2022 оны 07 дугаар сард УИХ-д өргөн мэдүүлсэн боловч хэлэлцүүлгийн шатанд буцаан татсан байна.

3.2. Танай улсын Үндсэн хууль, эсхүл бусад хууль тогтоомжоор парламент нь асуулга авах, сонсгол хийх, тодруулга авах, газар дээр нь очиж үзэх зэргээр засгийн газрын хариуцлагын тогтолцоог сайжруулж чадаж байна уу?

Парламентаас хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл болох асуулт, асуулга тавих, газар дээр нь танилцах, хяналт шалгалт хийх бүрэн эрхийг Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулсан. 2015 онд Нийтийн сонсголын тухай хууль батлагдсанаар төрийг удирдах хэрэгт иргэдийн оролцоог хангахад чиглэгдсэн нийтийн сонсголыг төрийн байгууллага, албан тушаалтан зохион байгуулахаар зохицуулсан. Энэ хуулиар сонсголын 9 төрлийг ангилсан бөгөөд сонсгол тус бүрийг зохион байгуулах дэгийг Нийтийн сонсголын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын Чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар тогтоосон. Үүнд: хууль тогтоох сонсгол, ерөнхий хяналтын сонсгол, төсвийн хяналтын сонсгол, томилгооны сонсгол, захиргааны хэм хэмжээний болон төлөвлөлтийн сонсгол, орон нутгийн сонсгол, танилцах сонсгол, зөвшилцөх сонсгол болон хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол хамаарна.

2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр парламентын хяналтын зарим бүрэн эрхийг нэмэгдүүлсэн. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан. Тус хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ дараах 7 арга хэрэгслээр хэрэгжүүлэхээр заасан. Үүнд:

1. асуулт тавих;
2. асуулга тавих;
3. хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх;
4. мэдээлэл сонсох, тайлан, илтгэл хэлэлцэх;
5. төсвийн хяналт;
6. хяналтын сонсгол хийх;
7. хянан шалгах түр хороо байгуулах.

УИХ-аас хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд баримтлах зарчмуудыг хуулийн 4 дүгээр зүйлд тусгасны нэг нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зарчим юм. Тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг; 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг; 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг; 26 дугаар зүйлд хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэгдсэн тодорхой заалтууд байдаг. Хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиг үүрэгтэй байгуулагдсан Хянан шалгах түр хороо, Түр хороо, ажлын хэсэг болон ерөнхий хяналтын сонсголын талаарх мэдээллийн тойм:

Хууль хэрэгжиж эхэлснээс хойш хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын ажлууд:

- УИХ-ын гишүүний асуулга, асуулт-24;
- Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн - 2;
- Хянан шалгах Түр хороо байгуулсан - 1;
- Түр хороо байгуулсан - 2;
- Ажлын хэсэг байгуулсан - 6;
- Хяналтын сонсгол хийсэн – 2.

Хянан шалгах түр хороо, хяналт шалгалтын ажлын хэсгүүдийн хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиглэлээр явуулсан үйл ажиллагаа:

Хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд нийт 56 хяналт шалгалтын ажил хийгдсэнээс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиглэлээр 9 удаа Хянан шалгах Түр хороо, Түр хороо, Ажлын хэсгүүд байгуулагдан ажилласан. Үүнээс:

- Хянан шалгах Түр хороо - 1;
- Түр хороо - 2;
- Ажлын хэсэг - 6.

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол:

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу нийт 14 удаа хяналтын сонсгол зохион байгуулснаас Хүний эрх, эрх

чөлөөг хамгаалахтай холбоотой 2 удаагийн хяналтын сонсголыг зохион байгуулсан. Үүнд:

- **2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр** Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны *“Дотоод орчны агаарын бохирдолтой холбоотой хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулах, үр нөлөөг сайжруулах, тухайн чиг үүрэг бүхий төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, мэдээлэл авах”* сэдэвт Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, сонсголын тайланг parliament.mn цахим хаягт байршуулсан.
- **2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр** Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны *“Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсэгт заасан хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах”* сэдэвт Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, сонсголын тайланг parliament.mn цахим хаягт байршуулсан.

УИХ-д Засгийн газар, холбогдох төрийн байгууллагуудаас хүний эрхийн асуудлаар илтгэл, тайлан хэлэлцүүлсэн байдал:

УИХТГ-ын ХШҮГ-ын мэдээллийн санд 2022.10.17-2023.10.17-ны өдрийн хооронд Засгийн газар, холбогдох төрийн байгууллагуудаас УИХ-д хүний эрхийн асуудлаар дараах 2 асуудлыг хэлэлцүүлсэн талаар бүртгэгдсэн байна. Үүнд:

- УИХ-ын НББХ-ны 2022.11.15-ны өдрийн хуралдаанаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх асуудлыг”; <https://www.parliament.mn/nn/18922/>
- УИХ-ын БСШУСБХ, НББХ хамтарсан 2023.04.12-ны өдрийн хуралдаанаар БШУ-ны сайд Л.Энх-Амгалан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалтын талаарх асуудлыг” тус тус хэлэлцүүлсэн. <https://www.parliament.mn/nn/29902/>

УИХ-ын гишүүдээс Хүний эрхийн асуудлаар тавьсан асуулт, асуулга:

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль батлагдсанаас хойш 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд Хүний эрхийн асуудлаар Улсын Их Хурлын 9 гишүүнээс 4 асуулт, 20 асуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас

бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагуудад хандаж тавьсан.

Эдгээрээс 6 асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар, 1 асуултын хариуг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн болно.

УИХ-аас ХЭҮК-ын илтгэлийг хэрхэн авч хэлэлцсэн талаарх мэдээлэл

УИХ-аас ХЭҮК-ын тайлан илтгэлийг авч хэлэлцүүлэх тухай Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Монгол Улсын Хүний Эрхийн үндэсний Комиссын тухай хуулиудын дагуу авч, хэлэлцэж байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг Улсын Их Хурал жил бүр хэлэлцэх тухай, мөн 16.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлд Улсын Их Хурлын Тамгын газраас шинжилгээ хийж, шинжилгээ хийсэн талаарх танилцуулгыг холбогдох Байнгын хороонд хүргүүлэх тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2.3 дахь хэсэгт заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг Хууль зүйн байнгын хороо болон холбогдох бусад байнгын хороо хаврын ээлжит чуулганы хугацаанд хэлэлцэх тухай, Монгол Улсын Хүний Эрхийн үндэсний Комиссын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд хүргүүлэх тухай, мөн 9.2 дахь хэсэгт Комиссын илтгэлийг жил бүрийн Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, илтгэлээр өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Улсын Их Хурал тогтоол гаргахаар заасан.

УИХ нь тогтоол гаргахдаа ХЭҮК-ын илтгэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр ЗГ-т чиглэл өгдөг бөгөөд хэрэгжилт нь зарим талаар хангалтгүй байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль 2020 онд шинэчлэн батлагдсан бөгөөд түүнээс хойш хугацаанд Хүний эрхийн Үндэсний Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20, 21, 22 дахь илтгэлийг бэлтгэн УИХ-д хүргүүлж, хэлэлцүүлсэн.

3.3. Парламент хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүний эрхийн үр нөлөөг дүгнэх, үнэлэх журам, аргачлалыг боловсруулсан уу? Үүнд тодорхой эмзэг бүлгийн хувьд ялгаварлан гадуурхлын үр нөлөөг бий болгож болзошгүй хуулиудад хийх үнэлгээ дүгнэлт мөн багтдаг уу?

Парламентын түвшинд Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 77 дугаар захирамжаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх журам”-д үнэлгээ хийх ажлыг төлөвлөхдөө Монгол Улсын ХЭҮК-оос хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал ирүүлсэн бол төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар боловсруулахдаа харгалзан үзнэ гэж тусгасан ба одоогоор энэ зохицуулалтын дагуу хууль тогтоомжид тусгайлан хүний эрхийн үнэлгээ хийгдээгүй байна.

УИХ-ын хууль тогтоох, хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх чадавхыг бэхжүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөний 3.1.8-д “хуулийн төслүүд хүний эрхийг хангасан эсэхэд нөлөөллийн үнэлгээ хийж, Хүний эрхийн олон улсын конвенц болон НҮБ-аас хүний эрхийн талаар гаргасан зөвлөмжүүдтэй нийцүүлж баталдаг болох” зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд УИХ-ын Тамгын газрын ХЭЗГ-ын бүтцэд Эрх зүйн дүн шинжилгээний хэлтэс, мөн ХШҮГ-ын бүтцэд Төсвийн шинжилгээний хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээний алба байгуулагдсан бөгөөд эдгээр нэгжүүд нь УИХ-д өргөн барьсан хуулийн төсөл болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэгтэй ажилладаг. ЭЗДШХ 2021 онд 3 хуулийн төсөлд, 2022 онд 5 хуулийн төсөлд, 2023 онд 3 хуулийн төсөлд эрх зүйн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан байна. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлд Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зарчмыг баримтлахыг хуульчилсан. Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3-т Улсын Их Хурал Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг жил бүр хэлэлцэнэ гэж заасан. Хуулийн 16.1-д тайланд ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газар шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд тараана гэснийг удирдлага болгон УИХТГ-аас 2021 онд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, 2022 онд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлд тус тус шинжилгээ хийсэн.

2023 онд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг УИХ-аар хэлэлцсэн боловч УИХТГ-аас шинжилгээ хийгээгүй байна.

ХЭҮК 2001 оноос хойш хүний эрхийн асуудлаар 108 судалгааны ажлыг хийсэн. Үүнээс 2011-2021 онд 58 судалгааны ажил хийжээ. Судалгаа, үнэлгээний үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг хүний эрх, чөлөөний байдлын талаарх илтгэлд тусган УИХ-д танилцуулж байна.

Мөн ХЭҮК-ын зүгээс Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ (ХЭНБҮ)-ний аргачлал боловсруулсан ба ХЭНБҮ нь тодорхой бодлого, хөтөлбөр, төсөл, бизнесийн үйл ажиллагааны улмаас хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөөллийг илрүүлэх, тодорхойлох, үнэлэх, арилгах буюу бууруулах арга хэмжээ авах үйл явц юм. ХЭНБҮ нь хэт ерөнхий, хийсвэр хандлагаар хандаж үр дүн багатай байсан хүний эрхийн асуудлыг нарийвчлан тодорхойлох, баримтаар үндэслэх, шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой. Ялангуяа бизнесийн байгууллагуудад хүний эрхийн ойлголтыг бодит туршлагаар, хөрсөнд буулгаж ойлгуулах, хэрэгжүүлэх хандлагыг төлөвшүүлэхэд үр дүнтэй байдаг. ХЭНБҮ-ний нэг чухал давуу тал нь байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн үнэлгээнд тусгагдаагүй асуудлыг нарийвчлан авч үзэх бололцоог олгодгоороо чухал ач холбогдолтой юм.¹²⁵

Цаашилбал ХЭҮК-ын зүгээс хүний эрхийн нэр томъёоны тайлбар боловсруулж, эрдэмтэн судлаач төдийгүй иргэд, олон нийтийн хүний эрхийн боловсрол, хүний эрхийн түгээмэл соёлыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулж байна. ХЭҮК-ын зүгээс Үндэсний статистикийн хороо, Хүний эрхийг хангах Үндэсний хороотой хамтран, манай улсад анх удаа Хүний эрхийн үндэсний индекс боловсруулж, нийгмийн бүлгийн мэдээлэл, тэдэнд тулгамдсан асуудлыг бодитой, итгэхүйц, найдвартай байдлаар баримтжуулан судлах, мөшгих, сан бүрдүүлэх зорилготой ажиллаж байна.

3.4. Олон улсын хүний эрхийн ямар гэрээнд танай улс нэгдэн ороогүй байгаа вэ? Танай улс нэгдэн орсон хүний эрхийн гэрээний ямар заалтуудыг түр зогсоосон бэ? Түр зогсоосон шийдвэртэй холбоотойгоор гэрээний байгууллагуудаас хийсэн сүүлийн үеийн дүгнэлт ажиглалтыг уншиж танилцсан уу?

Монгол Улс Хүний эрхийн суурь 10 гэрээ, тэдгээрийн Нэмэлт Протоколуудаас “Бүх цагаач ажилчид, тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц” (International Convention on the Protection of the Rights of All Migrant Workers and Members of Their Families 18 Dec 1990)-д нэгдэн ороогүй. Тус конвенцод Монгол Улс хоёр их гүрний дунд орших, далайд гарцгүй, цөөн хүн амтай орны хувьд эдийн засаг, хүн ам зүйн бодлого болоод үндэсний аюулгүй байдлын үүднээс одоогоор нэгдэн ороогүй байна.

¹²⁵ ХЭҮК, Бодлогын инновацийн хүрээлэн, НҮБХХ, Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ (ХЭНБҮ) гарын авлага, Улаанбаатар хот, 2020 он. 9 дэх тал.

Сүүлийн 12 сарын хугацаанд:

Засгийн газар олон улсын хэмжээнд сүүлийн үед хийж буй үйл ажиллагааны талаар парламентад мэдээлэл хийсэн үү?

Сүүлийн 12 сарын хугацаанд тухайн асуудлаар мэдээлэл хийгдээгүй байна.

Чуулганаар хүний эрхийн асуудлаар засгийн газарт асуулт, асуулга тавьж, хангалттай мэдээлэл авч чадсан уу?

2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанаас 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд хүний эрхийн асуудлаар Улсын Их Хурлын 9 гишүүнээс Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагуудад хандаж нийт **4** асуулт, **20** асуулга тавьж, хариултаа авсан байна. Үүнд:

Асуулт:

1. УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт хандаж “Шүүхийн шийдвэргүйгээр цагдан хорих явдал онцгой тохиолдол гэхээсээ илүү жирийн үзэгдэл хэвээр байгаа, мөн иргэдийг цагдаагийн байгууллагад хуульч байлцуулахгүйгээр байцаалт авдаг байдал хэвшмэл байгаа”, “эрүүгийн мөрдөн байцаагч, прокурорууд асар их, хяналтгүй эрх мэдэл эдэлж байхад талуудын эрх тэгш байдлыг үл тоомсорлон шүүгдэгчдэд зохих хууль эрх зүйн журмын бүхий л баталгааг хангаж өгөхгүй байгаа нь санаа зовоож байна”, “хүний эрхийг хамгаалагчдын хууль ёсны ажилд саад учруулах, ялангуяа тэдний стратегийн хөгжлийн төслүүдийг эсэргүүцэж, тайван замаар үзэл бодлоо илэрхийлэх, цуглаан, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлахад ашиглагдаж болзошгүйд анхаарал хандуулж байна” зэрэг олон асуудлуудын талаар “Ажлын хэсгийн дүгнэлтийг тодруулах тухай”;
2. УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд хандаж “Сургуулийн орчинд үйлдэгддэг зарим гэмт хэргийн талаар”;
3. УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт хандаж “Сургуулийн орчинд үйлдэгддэг зарим гэмт хэргийн талаар”;
4. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлд хандаж “Коронавируст халдвар “КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар” зэрэг асуултуудыг тус тус асуусан байна.

Асуулга:

1. УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэнгээс Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж ““Элэг бүтэн Монгол” Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар”;
2. УИХ-ын гишүүн Ц.Туваанаас Эрүүл мэндийн сайд С.Энхболдод хандаж “Эм үйлдвэрлэл, эмийн үнийн талаар”;
3. УИХ-ын гишүүн М.Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж “Эмийн үйлдвэрлэл, чанар, хяналт, хүртээмжийн зэрэг асуудал болон энэ талаарх цаашдын бодлого, зорилтын талаар”;
4. УИХ-ын гишүүн Т.Доржхандаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж “Иргэний улс төрийн эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн талаар”;
5. УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатараас Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд хандаж “Махны чанар, түүнд тавих хяналтын талаар”;
6. УИХ-ын гишүүн Б.Баярсайханаас Эрүүл мэндийн сайд С.Энхболдод хандаж “Хүн амын нийтийн эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай”;
7. УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж “Улсын Их Хурлын 21 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар”;
8. УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж ““Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-ний үр дүнгийн талаар”;
9. УИХ-ын гишүүн Б.Баярсайханаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд хандаж “Малчдын өмнө тулгамдаж буй асуудлын талаар”;
10. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
11. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
12. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
13. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Зам, тээврийн хөнжлийн сайд С.Бямбацогтод хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;

14. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
15. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Сангийн сайд Б.Жавхланд хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
16. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
17. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваад хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
18. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
19. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Сангийн сайд Б.Жавхланд хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
20. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж “Улаанбаатар хотын утаа болон сайжруулсан шахмал түлшний талаар” зэрэг асуулгуудыг тус тус тавьсан байна.

Хуулийн хэрэгжилт хүний эрхийн хувьд үзүүлж буй үр нөлөөг үнэлэх асуудлыг тогтмол (чуулганаар/ хорооны хурлаар) хэлэлцдэг үү?

УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооноос 2023.07.05-ны өдөр Хүүхдийн эрхийн тухай хуульд заасан хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол хийсэн. Улмаар 2023.10.06-ны өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаарх мэдээллийг сонсож, хүүхдийн эрхийн нээлттэй сонсгол хийхийг холбогдох байнгын хороонд даалгасны дагуу Хууль зүйн байнгын хорооноос 2023.10.25-ны өдөр Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар хяналтын сонсгол зохион байгуулсан.

Хүний эрхийн тодорхой асуудлаар парламент судалгаа хийх, асуулга явуулах, эсхүл баримт нотолгоо илрүүлэх ажлыг хийсэн үү? Хэрэв тийм бол, эдгээр ажлын үр дүн, үр нөлөө юу байв?

УИХТГ-ын бүтцэд Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн ажилладаг бөгөөд тус хүрээлэн нь УИХ-ын гишүүдийг судалгаа, мэдээллээр хангаж

ажилладаг. Тус хүрээлэнгээс хүний эрхийн чиглэлээр УИХ-ын гишүүдийн санаачлан боловсруулж буй хуулийн төсөл болон УИХ-аар хэлэлцэн баталж буй асуудалд хамаарах дараах судалгааны ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Улсын төсвийн тухай хуулийн төсөл хүний эрхэд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй, ядуурлыг бууруулахад чиглэсэн эсэх шалгуур үзүүлэлтийг шалгах хуудас боловсруулах судалгаа СТ-21/250;
- Хүний эрхийн боловсрол олгох тогтолцоо ба парламентын оролцооны талаарх харьцуулсан судалгаа СТ-21/234;
- Үндсэн хуулийн цэц (шүүх)-ээр хүний эрхийн маргааныг шийдвэрлэхтэй холбоотой бусад орнуудын туршлага СТ-23/207;
- Хуулийн төсөлд хууль зүйн дүгнэлт гаргах болон хүний эрхийг хангасан эсэхэд үнэлгээ хийх аргачлалын талаарх бусад орны туршлага СТ-21/252;
- Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын зохицуулалт: гадаадын зарим орны туршлага СТ-21/209;
- Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хүний эрх ба хүний эрхийн боловсрол СТ-21/411;
- Хүний эрхийн институцийн загварууд, омбудсмэний тогтолцоо, үйл ажиллагааны хэлбэр, эрх зүйн байдал СТ-19/201;
- Парламентын Хүний эрхийн хороод, тэдгээрийн үйл ажиллагааны талаарх гадаадын зарим орны туршлага СТ-18/221;
- Мандатын эрх, Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, Байцаан шинжих түр хороо, түүний бүрэн эрх, Хүний эрхийн омбудсмэн, Авлигатай тэмцэх омбудсмэн, Төсвийн аудитын талаарх харьцуулсан судалгаа СТ-09/217.

Хүний эрхийн шууд холбогдолтой, тодорхой асуудлаар баримт нотолгоо илрүүлэх ажлын хүрээнд УИХ-ын зарим гишүүд бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газрын холбогдох сайд нараас дараах асуулт, асуулгад хариулт авсан байна. Үүнд:

- УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт хандаж “Шүүхийн шийдвэргүйгээр цагдан хорих явдал онцгой тохиолдол гэхээсээ илүү жирийн үзэгдэл хэвээр байгаа, мөн иргэдийг цагдаагийн байгууллагад хуульч байлцуулахгүйгээр байцаалт авдаг байдал хэвшмэл байгаа”, “эрүүгийн мөрдөн байцаагч, прокурорууд асар их, хяналтгүй эрх мэдэл эдэлж байхад талуудын эрх тэгш байдлыг үл тоомсорлон шүүгдэгчдэд зохих хууль эрх зүйн журмын бүхий л баталгааг хангаж өгөхгүй байгаа нь санаа зовоож байна”, “хүний эрхийг

- хамгаалагчдын хууль ёсны ажилд саад учруулах, ялангуяа тэдний стратегийн хөгжлийн төслүүдийг эсэргүүцэж, тайван замаар үзэл бодлоо илэрхийлэх, цуглаан, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлахад ашиглагдаж болзошгүйд анхаарал хандуулж байна” зэрэг олон асуудлуудын талаар “Ажлын хэсгийн дүгнэлтийг тодруулах тухай”;
- УИХ-ын гишүүн Т.Доржхандаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж “Иргэний улс төрийн эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн талаар”.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АСУУЛТ 5. НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТАЙЛАГНАХ МЕХАНИЗМ ДАХЬ ПАРЛАМЕНТЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Сэдвийн тойм

Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулиар олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үндэсний тайланг боловсруулах үүргийг Монгол Улсын Засгийн газар хэрэгжүүлдэг бөгөөд тайланг бэлтгэх ажлыг зохион байгуулах, хүргүүлэх, хэлэлцүүлэхтэй холбоотой журам болон тайланг хариуцан боловсруулах байгууллагын хуваарийг Засгийн газраас баталдаг.

Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоонд онцгой үүрэгтэй субъектын хувьд УИХ-аас хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхийнхээ хүрээнд НҮБ-ын хүний эрхийн тайлагнах механизмд оролцож байна. Тухайлбал, УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, түүний бүрэлдэхүүнд ажилладаг Хүний эрхийн дэд хороогоор хүний эрхийн олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, НҮБ-ын гэрээний байгууллагуудад илгээж буй Засгийн газрын тайлан, эдгээр байгууллагуудаас Засгийн газарт өгсөн зөвлөмжийн хэрэгжилт зэргийг хэлэлцэн санал дүгнэлт гаргах, шаардлагатай зарим асуудлыг Хууль зүйн байнгын хороогоор дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулах боломжтой. Мөн УИХ-ын бусад байнгын хороод өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хүний эрхийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Засгийн газраас боловсруулсан тайлангийн төслийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргах боломжтой.

Одоогийн байдлаар Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хууль болон ЗГ-ын “Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам”-ын хүрээнд НҮБ-ын хүний эрхийн үндэсний тайланг боловсруулахад УИХ-ын зүгээс шууд оролцох зохицуулалт байхгүй. Хэдий тийм ч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн үндэсний тайлан, гаргасан шийдвэрийг холбогдох хуульд заасны дагуу УИХ-д хүргүүлдэг бөгөөд энэ хүрээндээ УИХ-ын гишүүд мэдээлэл авч ажиллаж байна. Харин хүний эрхийн олон талт гэрээг Улсын Их Хурал заавал соёрхон батлахаар Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулиар зохицуулсан. Иймд цаашид соёрхон баталж нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн байдлыг Улсын Их Хурлаар тогтмол хэлэлцдэг байх нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх ажилд ахиц авчрах юм.

НҮБ-ын хүний эрхийн мониторингийн чухал механизмын нэг болох тусгай илтгэгч, төлөөлөгч, ажлын хэсэг ихэвчлэн Монгол Улсын Засгийн газрын урилгаар ирдэг боловч УИХ-ын дарга, гишүүд болон холбогдох Байнгын

хорооны гишүүдтэй уулзаж бодлого, эрх зүйн орчин, тогтолцооны талаар мэдээлэл авахаас гадна хүний эрхийн тодорхой асуудлаар нөхцөл байдлыг үнэлэхэд шаардлагатай мэдээлэл авдаг. 2017 оноос хойш Монгол Улсад НҮБ-ын тусгай илтгэгч, төлөөлөгч 6 удаа ирсэн бөгөөд хамгийн сүүлд хэдхэн хоногийн өмнө Шүүгч, өмгөөлөгчдийн хараат бус байдлын асуудал хариуцсан НҮБ-ын тусгай илтгэгч Маргарет Саттертуэйт хүрэлцэн ирж УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Хүний эрхийн дэд хорооны дарга Ц.Мөнхцэцэг нартай уулзсан байна.

5.1. Парламентад тухайн улс ба НҮБ-ын хүний эрхийн мониторингийн байгууллагын хоорондын хамтын ажиллагааны статусыг баталгаажуулах механизм байгаа юу? (тухайлбал, парламентын хүний эрхийн хороо, ажлын хэсэг, бүлэг, тусгай комисс)

НҮБ-ын Хүний эрхийн механизмууд

НҮБ-ын хүний эрхийн механизмд 1) Хүний эрхийн суурь гэрээний байгууллагууд, 2) Хүний эрхийн зөвлөл, 3) Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR - Universal Periodic Review) хамаарч байна.

1. Хүний эрхийн суурь гэрээний байгууллагууд

Хүний эрхийн тухай суурь 9 гэрээ, тэдгээрийн нэмэлт протоколын хэрэгжилтийг хангах бие даасан шинжээчдээс бүрдсэн байгууллагуудыг хэлнэ. Үүнд:¹²⁶

1. Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц;
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт;
3. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт;
4. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц;
5. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц;
6. Хүүхдийн эрхийн тухай конвенц;
7. Бүх цагаач ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц /Монгол Улс хараахан соёрхон батлаагүй/;
8. Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц;
9. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц.

¹²⁶ <https://www.ohchr.org/en/core-international-human-rights-instruments-and-their-monitoring-bodies>

2. Хүний Эрхийн зөвлөл (Хүний Эрхийн Комисс)¹²⁷

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны 03-р сарын 15-ны өдрийн 60/251 тоот тогтоолоор¹²⁸ НҮБ-ын Хүний эрхийн Комиссыг Хүний эрхийн зөвлөл болгон өөрчлөн байгуулж, “гишүүн бүх улсынхаа хүний эрхийн үүрэг, амлалтынх нь биелэлтийн талаар үнэн бодит мэдээлэлд үндэслэн, тэдэнд шударга бөгөөд бүхий л хүрээний асуудлыг хамруулан дүгнэлт хэлэлцүүлэг хийх” эрхийг Хүний эрхийн зөвлөлд олгосон.

2007 оны 06-р сарын 18-нд Хүний эрхийн зөвлөлийн шинэ гишүүд баталсан зөвлөлийн ирээдүйн ажлын удирдамжийг агуулсан зохион байгуулалтын баримт бичиг¹²⁹ (А/ХЭЗ/шийдвэр/5/1)-ийн нэг үндсэн хэсэг нь Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг - UPR-ийн тухай байсан юм.

3. UPR-ийн тухай ойлголт

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR - Universal Periodic Review) нь НҮБ-ын гишүүн 192 орны хүний эрхийн төлөв байдлыг 4 жил тутам дүгнэн хэлэлцэх механизм юм.

UPR нь бүх улс оронд ялгаваргүй, тэгш хандах, хэлэлцүүлэгт орж байгаа улстай хамтран ажиллах зарчимд үндэслэдэг ба улс орнууд дахь хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах, хүний эрхийг хангахад тулгарч буй бэрхшээлүүдийг даван туулахад төр засагт туслах, техникийн туслалцааны асуудлыг ч мөн авч үздэг нэгэн онцлогтой юм.

UPR-ийн зорилго нь дэлхийн бүх хүний тусын тулд улс орнуудын хүний эрхийн нөхцөл байдлыг газар дээр нь сайжруулахад оршино. Энэ зорилгодоо хүрэхийн тулд улс орнууд дахь хүний эрхийн төлөв байдлыг үнэлэх, хүний эрх зөрчигдөх тохиолдол бүрд анхаарлаа хандуулах боломжийг эрэлхийлэх бөгөөд улс орнуудад техникийн туслалцаа үзүүлэх, хүний эрхийн салбар дахь сайн туршлагаа хуваалцах, бие биенээсээ суралцах боломжийг олгох, хүний эрхийн асуудлаа сайнаар шийдвэрлэх чадавхыг бэхжүүлдэг байна.

Монгол Улсын хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо

Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог өргөн хүрээгээр авч үзвэл, Ерөнхийлөгч, УИХ, ЗГ, Хүний эрхийн үндэсний комисс, шүүх, прокурор, ҮХЦ, өмгөөлөх гэх мэт хүний эрхийг хамгаалах шууд үүрэг, зорилго бүхий төрөлжсөн байгууллагууд, бүх шатны төрийн захиргааны болон нутгийн

¹²⁷ <https://www.ohchr.org/en/hrbodies/hrc/home>

¹²⁸ <https://www.ohchr.org/en/hr-bodies/upr/basic-facts>

¹²⁹ <https://upr-mongolia.mn/images/xupld/51mon.pdf>

өөрөө удирдах байгууллага, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хувийн хэвшил, хүний эрхийн хангах, хамгаалах ажлын алба, тэдгээртэй адилтгах дотоодын хэрэгслүүдийг багтаадаг. Үүнээс УИХ буюу УИХ дахь Хүний эрхийн дэд хорооны талаар дэлгэрүүлж авч үзэв.

УИХ-ын Хүний эрхийн дэд хороо (ХЭДХ)

Улсын Их Хурал нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд онцгой хариуцлага хүлээдэг. УИХ энэ чиглэлд хууль тогтоомж баталдаг, хүний эрхийн олон улсын гэрээнд нэгдэн орох эсэхийг шийддэг. УИХ улсын төсвийг батлахдаа хүний эрхийг хангахад шаардлагатай төсөв хуваарилагдаж, зориулалтын дагуу зарцуулагдсан эсэхийг хянан шалгадаг. УИХ нь мөн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд хүний эрхийг хүндэтгэх үүргээ биелүүлж буй эсэхэд хяналт тавих үүрэгтэй. Тиймээс, УИХ бүхэлдээ болон Хууль зүйн байнгын хороо, Төсвийн байнгын хороо зэрэг бүх байнгын хорооны үйл ажиллагаа хүний эрхийг хамгаалахад шийдвэрлэх нөлөөтэй.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар хүний эрх, эрх чөлөө, түүний баталгааг хангах үүрэг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд багтдаг бөгөөд түүний бүрэлдэхүүнд Хүний эрхийн дэд хороо (ХЭДХ) ажиллаж байна.¹³⁰

ХЭДХ нь парламентын хүний эрхийн хорооны нийтлэг жишгийн дагуу эрхлэх асуудлаа дагнан хариуцаж, санал, дүгнэлт гаргах, түүнийгээ Хууль зүйн байнгын хороонд, шаардлагатай бол Хууль зүйн байнгын хороогоор уламжлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, хариуцсан асуудлынхаа хүрээнд хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

ХЭДХ нь УИХ-ын бусад дэд хорооны нэгэн адил дараах бүрэн эрхтэй. Үүнд: хүний эрхийн, эсхүл эрхлэх бусад асуудлаараа хяналт-шалгалт, судалгаа хийх, холбогдох мэдээлэл авах, зохих албан тушаалтан, иргэн, байгууллагаас тайлбар авах, ажлын хэсэг байгуулах, эрхэлсэн асуудлынхаа хүрээнд тогтоол гаргах, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулж, харьяалах Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх эрхтэй. Жишээлбэл, хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагыг судалж, хүний эрх зөрчигдөх үндэслэлийн талаар санал, дүгнэлт гаргаж Хууль зүйн байнгын хороогоор дамжуулан УИХ-д уламжилж болно. Түүнчлэн ХЭДХ нь хүний эрхийн олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, НҮБ-ын гэрээний байгууллагуудад илгээж буй засгийн газрын тайлан, эдгээр байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмжийн хэрэгжилт зэргийн талаар санал, дүгнэлт гаргах боломжтой.

¹³⁰ Монгол Улс дахь Хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл. Улаанбаатар, 2021 он, О.Мөнхсайхан, Р.Очирбал

Мөн Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улс олон улсын байгууллагад элсэх тухай асуудлыг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарч, авч хэлэлцдэг.

5.2. НҮБ-ын хүний эрхийн мониторингийн байгууллагын талаар парламентад байнга мэдээлэл өгдөг үү? Парламентын ажлын албаны ажилтнууд, ХЭҮК, иргэний нийгмийн байгууллагууд холбогдох мэдээллийг тогтмол авах боломжтой байдаг уу?

НҮБ-ын хүний эрхийн мониторингийн байгууллагын талаарх мэдээлэл болон хүний эрхийн талаарх асуудал нь Монгол Улсын Их Хурлын тухай хуульд зааснаар Хууль зүйн байнгын хороо болон Хүний эрхийн дэд хорооны харьяалах асуудалд хамаарч, тус хуульд заасны дагуу эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцан санал, дүгнэлт гаргаж, түүнийгээ харьяалагдах Байнгын хороонд, шаардлагатай бол Байнгын хороогоор уламжлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлдэг. Тодруулбал,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар хүний эрхийн асуудлаар тайлан, илтгэл, мэдээллийг сонсох, хэлэлцэх дэгийг зохицуулсан бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаар 2 жил тутам, Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэлийг жил бүр Хууль зүйн байнгын хороо болон холбогдох байнгын хороогоор мэдээлэл сонсож, хэлэлцэж байна.

УИХ-аас 2021 онд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүд, тэдгээрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, НҮБ-аас өгсөн зөвлөмжийг судлан Улсын Их Хуралд танилцуулах Ажлын хэсгийг байгуулж, уг ажлын хэсгээс гаргасан тайлан, дүгнэлтийг 2023 оны хаврын чуулганы хугацаанд ХЗБХ, АБГББХ, НББХ зэрэг УИХ-ын байнгын хороодоор хэлэлцсэн бөгөөд УИХ-аас Засгийн газарт чиглэл өгсөн тогтоолын төслийг боловсруулж байна. Уг ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил ахлан ажиллаж байна.

УИХ-аас жил бүр ХЭҮК-ын тайланг хэлэлцэхдээ Монгол Улсын хүний эрхийн үндэсний тайлангийн мониторингийн дүн, холбогдох зөвлөмжийн талаар мэдээлэл авч, Засгийн газраас оруулсан саналын дагуу бодлого, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэдэг.

5.3. Парламент, эсхүл эрх бүхий хороо улс орны хүний эрхийн тайланг боловсруулахад оролцдог уу?

Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулиар Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд

хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулахаар (Монгол Улсын Олон Улсын гэрээний тухай хуулийн §24.4.) заасан байдаг.

Мөн Монгол Улсын Засгийн газраас “Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам”¹³¹-ыг 2017 онд шинэчлэн баталсан бөгөөд уг журмаар тайлан бэлтгэх ажлыг зохион байгуулах, хүргүүлэх, хэлэлцүүлэх асуудлыг зохицуулахаас гадна олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан хариуцан боловсруулах байгууллагын хуваарийг баталсан байна. Энэ хуваарийн дагуу холбогдох байгууллагууд үндэсний тайланд орох мэдээ, мэдээллүүдийг гаргаж байна.

Монгол Улсаас НҮБ-ын Хүний эрхийн механизмд хүргүүлэх Үндэсний тайланг 2010 оноос хойш 3 удаа явуулсан.

Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулиар болон ЗГ-ын “Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам”-аар Парламент болон эрх бүхий хороо энэ тайланг боловсруулахад оролцох зохицуулалт байхгүй байна.

5.4. Хүний эрхийн гэрээний байгууллагуудад улс орны өргөн мэдүүлэх үндэсний тайлантай холбоотой тайлагнах хуваарийн талаар парламентын гишүүд мэддэг үү?

Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулиар Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулах (Монгол Улсын Олон Улсын гэрээний тухай хуулийн §24.4.) үүрэгтэй.

Монгол Улсын Засгийн газраас “Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам”¹³²-ыг 2017 онд шинэчлэн баталсан бөгөөд тус журам нь тайлан бэлтгэх ажлыг зохион байгуулах, хүргүүлэх, хэлэлцүүлэх талаар зохицуулахаас гадна олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг хариуцан боловсруулах байгууллагын хуваарийг хавсралтаар гаргасан байна. Энэ хуваарийн дагуу холбогдох байгууллагууд үндэсний тайланд орох мэдээ, мэдээллүүдийг гаргаж байна.

Тус журамд зааснаар Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх (журмын 2.8.) бөгөөд засгийн газраас гарсан тогтоолыг

¹³¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12817>, Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам, МУЗГ-ын 2017.07.04-ны өдрийн 193-р тогтоол.

¹³² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12817>, Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам, МУЗГ-ын 2017.07.04-ны өдрийн 193-р тогтоол.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны Ерөнхий хуульд заасны дагуу УИХ-д хүргүүлж, түүний дагуу УИХ-ын гишүүдийг мэдээлэлжүүлж ажиллаж байна.

5.5. Олон улсын хүний эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч, төлөөлөгч парламентад ирж ажилласан эсэх. УИХ-ын гишүүдтэй уулзалт хийсэн байдал

Хүний эрхийн зөвлөл (НҮБ, ХЭДКГ)-ийн тусгай илтгэгч, төлөөлөгч

Тусгай илтгэгч, төлөөлөгчийн тогтолцоо нь НҮБ-ын хүний эрхийн механизмын чухал бүрэлдэхүүн юм. Эдгээр хүмүүс нь хүний эрхийн талаар сэдэвчилсэн мэдээлэл хийх, улс орны онцлогийг таньж мэдэх, зөвлөгөө өгөх эрх бүхий хараат бус, бие даасан хүний эрхийн шинжээчид юм. Тэд НҮБ-ын ажилтан биш бөгөөд санхүүгийн урамшуулал авдаггүй. Тэднийг гурван жилээр сонгодог бөгөөд дахин гурван жилээр сунгах боломжтой.¹³³ НҮБ-ын тусгай илтгэгч, төлөөлөгчид ихэвчлэн Монгол Улсын Засгийн газрын урилгаар ирдэг бөгөөд ингэхдээ УИХ-ын дарга, гишүүд болон холбогдох байнгын хороотой уулзаж хууль эрх зүйн орчин, тогтолцооны талаар мэдээлэл авдаг. 2017 оноос хойш Монгол Улсад ирсэн олон улсын тусгай илтгэгч, төлөөлөгчдийн мэдээлэл:

2023.11.06-ны өдөр НҮБ-ын тусгай илтгэгч Маргарет Саттертуэйт Монгол Улсад хийсэн айлчлал

Шүүгч, өмгөөлөгчдийн хараат бус байдлын асуудал хариуцсан НҮБ-ын Тусгай илтгэгч Маргарет Саттертуэйт 2023 оны 11 дүгээр сарын 06-наас 15-ны өдрүүдэд ажлын айлчлал хийсэн.

Айлчлалын үеэр 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр УИХ-ын гишүүн, ХЗБХ-ны дарга Д.Цогтбаатар, УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Ц.Мөнхцэцэг нартай албан уулзалт хийж, шүүгч, шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хангах, хуульчийн мэргэшлийн үйл ажиллагааг хараат бусаар эрхлэх нөхцөл, шүүгчдийн нийгмийн асуудал, тус салбарын шинэчлэлийн талаар санал солилцов.

2022.10.14-ний өдөр НҮБ-ын ажлын хэсэг Монгол Улсад хийсэн айлчлал

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хууль бусаар саатуулах ажлын хэсэг Засгийн газрын урилгаар 2022 оны 10-р сарын 03-аас 10-р сарын 14-ний өдрүүдэд Монгол Улсад ажилласан.

¹³³ <https://www.ohchr.org/en/special-procedures-human-rights-council/special-procedures-human-rights-council>

Ажлын хэсэг нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2020)-ын эерэг өөрчлөлтүүдийг сайшааж мөн Хүний эрхийг хамгаалагчийн тухай, Өршөөлийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай зэрэг хэд хэдэн хуулийн ололт, сорилтыг тодорхойлсон.

Айлчлалын хүрээнд холбогдох албан тушаалтнуудтай уулзахын зэрэгцээ УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны даргатай уулзсан.¹³⁴

2021.12.08-ны өдөр НҮБ-ын тусгай илтгэгч Рим Алсалемын Монгол Улсад хийсэн айлчлал

НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан, үр дагаврын асуудлаарх тусгай илтгэгч Рим Алсалем 2021 оны 11-р сарын 29-нөөс 12-р сарын 08-ны өдрүүдэд Монгол Улсад айлчилсан.

Айлчлалын зорилго нь эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх эрх зүйн болон институцийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр хийгдсэн ажлыг үнэлж дүгнэх, ололт, амжилтыг тэмдэглэх явдал байв.

Айлчлалын хүрээнд холбогдох албан тушаалтнуудтай уулзахын зэрэгцээ УИХ-ын дарга болон УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны даргатай уулзсан.¹³⁵

2019.09.11-ний өдөр НҮБ-ын шинжээч Хуан Пабло Бохославскийн Монгол Улсад хийсэн айлчлал

НҮБ-ын Хүний бүхий л эрх, ялангуяа эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ бүрэн эдлэхэд улс орнуудын гадаад өр болон бусад холбогдох олон улсын санхүүгийн үүргийн нөлөөллийн талаарх хараат бус шинжээч Хуан Пабло Бохославский 2019 оны 09-р сарын 02-ноос 09-р сарын 11-ний өдрүүдэд Монгол Улсад айлчилсан.

Айлчлалын зорилго нь а) өрийн болон макро эдийн засгийн бодлогыг хүний эрхийн үүднээс судлах, б) ашигт малтмалын түрээсийг нийгэм, байгаль орчныг хамарсан, цогц бодлого болгон хувиргаж, хүний эрхийг шат дараатай хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах, в) хууль бус санхүүгийн урсгал, түүний хүний эрхэд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлж буй зарим хүчин чармайлтыг үнэлэх; г) дэд бүтэц, уул уурхайн төслүүд болон гадаадын бусад шууд хөрөнгө оруулалтын зээлийг хүний эрхийн үүднээс авч үзэх гэсэн 4 асуудлын хүрээнд байв.

¹³⁴<https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G23/129/21/PDF/G2312921.pdf>

¹³⁵<https://www.ohchr.org/en/statements/2021/12/united-nations-special-rapporteur-violence-against-women-its-causes-and>

Айлчлалын хүрээнд холбогдох албан тушаалтнуудтай уулзахын зэрэгцээ Төрийн өндөр албан тушаалтнуудтай уулзсан.¹³⁶

2019.05.13-ны өдөр НҮБ-ын тусгай илтгэгч Мишель Форстын Монгол Улсад хийсэн айлчлал

НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын тусгай илтгэгч Мишель Форст 2019 оны 04-р сарын 30-наас 05-р сарын 13-ны өдрүүдэд Монгол Улсад айлчилсан.

Айлчлалын гол зорилго нь хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлыг олон улсын хэмжээнд хүлээсэн үүрэг, амлалтын хүрээнд үнэлэх явдал байв.

Айлчлалын хүрээнд холбогдох албан тушаалтнуудтай уулзахын зэрэгцээ УИХ-ын дарга болон УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны даргатай уулзсан.¹³⁷

2017.09.27-ны өдөр НҮБ-ын тусгай илтгэгч Жон Х.Ноксын Монгол Улсад хийсэн айлчлал

НҮБ-ын Хүний эрх, байгаль орчны асуудал хариуцсан Тусгай илтгэгч Жон Х.Нокс 2017 оны 09-р сарын 19-өөс 09-р сарын 27-ны өдрүүдэд Монгол Улсад айлчилсан.

Айлчлал нь аюулгүй, цэвэр, эрүүл, тогтвортой байгаль орчинтой холбоотой хүний эрхийн үүргийн хэрэгжилтийг дэмжих үүргийг НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс өгсөн.

Айлчлалын хүрээнд холбогдох албан тушаалтнууд, иргэний нийгмийн төлөөлөл, эрдэмтэн судлаачидтай уулзахын зэрэгцээ парламентын гишүүдтэй уулзсан.¹³⁸

5.6. НҮБ-ын Хүний эрхийн гэрээний хороодод хүргүүлэх тайлангийн боловсруулалт, тайлагнах процесст парламентын гишүүд орж ажилласан байдал

Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулиар болон Засгийн газрын “Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн

¹³⁶<https://www.ohchr.org/en/statements/2019/09/end-mission-statement-independent-expert-effects-foreign-debt-visit-mongolia>

¹³⁷<https://www.ohchr.org/en/statements-and-speeches/2019/05/visit-mongolia-30-april-13-may-2019-end-mission-statement>

¹³⁸<https://www.ohchr.org/en/statements/2017/09/statement-united-nations-special-rapporteur-john-h-knox-conclusion-his-mission>

хэрэгжилтийн тайлан боловсруулах журам”-аар Хүний эрхийн гэрээний хороодод хүргүүлэх тайлангийн боловсруулалт, тайлагнах явцад Улсын Их Хурлын гишүүд шууд оролцох, хувь нэмэр оруулах талаар нарийвчлан зохицуулаагүй байна. Өмнө дурдсан журмын дагуу олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан хариуцан боловсруулах байгууллагын буюу яамдын оролцоонд тулгуурлан тайланг бусад талтай хамтран боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлдэг. Энэ шатанд Улсын Их Хурлын гишүүн бөгөөд Засгийн газрын гишүүн асуудлыг нягтлах, нарийвчлан хэлэлцэх бүрэн боломжтой.

Сүүлийн 24 сарын хугацаанд:

НҮБ-ын хүний эрхийн гэрээний хороодод явуулах илтгэл, тайлангийн төслийг УИХ-аар авч хэлэлцсэн эсэх талаарх мэдээлэл

Монгол Улсын Их Хурал нь НҮБ-ын хүний эрхийн гэрээний хороодод явуулах илтгэл, тайлангийн төслийг УИХ-ын холбогдох байнгын хороо (АБГББХ) болон парламентаар авч хэлэлцээгүй байна. Засгийн газрын 2017 оны 193 дугаар тогтоолын Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журмын дагуу яамд, бусад төрийн байгууллага тайланг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн илгээдэг. Өмнө нь Гадаад харилцааны яам дангаар бүх олон улсын гэрээний хороодод илгээх илтгэл, тайланг хариуцаж, зарим талаар тайлагнах хугацаанаас хоцроож байсан учир олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг Яамдууд чиг үүргийн хүрээнд боловсруулдаг жишиг тогтсон юм. Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сард байгуулсан Хүний эрхийг хангах Үндэсний хорооны хуралдааны үеэр Үндэсний тайлан хянах мэдээллийн сан (National Recommendations Tracking Database), Хэрэгжилт, тайлан, биелэлт хариуцсан үндэсний механизм (National Mechanisms for Implementation, Reporting and Follow-up) бий болгох, шинэ бүтэц байгуулах талаар санал хэлэлцэж байжээ.

НҮБ-ын гэрээний хороод, UPR-т хүний эрхийн асуудлаарх үндэсний илтгэлийг танилцуулахад парламентын гишүүд оролцсон байдлын талаарх мэдээлэл

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний тайлангийн тухай

Монгол Улс нь НҮБ-ын гэрээний хороод болон НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэгт (UPR) 2010 оноос хойш 3 удаа үндэсний тайлангаа явуулжээ.

Эхний мөчлөг /2010.11.02/

Монгол Улс 2010 оны 11-р сарын 02-ны өдөр НҮБ-ын Хүний эрхийн ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-т анх удаа оролцсон. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан нийт 129 зөвлөмжөөс 126 зөвлөмжийг хэрэгжүүлэх амлалт авсан бөгөөд Монгол Улсын Засгийн газар нь 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдөр зөвлөмжүүдийг хэрхэн биелүүлсэн талаарх Үндэсний хоёрдугаар илтгэлээ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд хүргүүлсэн.

Хоёр дахь мөчлөг /2015.05.05/

Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэгт 2 дахь удаа орж, 2015 оны 05-р сарын 05-ны өдөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Нэгдсэн чуулганы үеэр 164 зөвлөмж өгснөөс 150 зөвлөмжийг хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан.

Гурав дахь мөчлөг /2020.05.05/

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-ийн Ажлын хэсгийн 36 дугаар чуулганаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлж, 170 зөвлөмжийг хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан.

Олон улсын хүний эрхийн байгууллагаас гаргасан зөвлөмж, дүгнэлтийг парламент авч хэлэлцэх процесс

УИХ-ын Аюулгүй байдлын байнгын хороо нь “Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улс олон улсын байгууллагад элсэх тухай асуудал” (Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн §24.1.6.)-ыг авч үзэх тул тус байнгын хороо нь шаардлагатай гэж үзвэл тайлангийн төслийг хэлэлцүүлэх асуудлаар санал, дүгнэлт гаргах боломжтой юм. Мөн Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулиар “Монгол Улсын олон улсын гэрээний үүргийн биелэлтэд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах талаар зөвлөмж, чиглэл өгч, шаардлагатай бол энэ тухай санал боловсруулж Улсын Их Хурал, эсхүл Засгийн газарт танилцуулна” (Олон улсын гэрээний тухай хуулийн §24.3.) гэсний дагуу УИХ-ын бусад байнгын хороод өөрийн эрхлэх асуудлын хүрээний зөвлөмж, дүгнэлтийг авч хэлэлцэх боломжтой.

Сүүлийн 24 сарын хугацаанд Монгол Улсын Их Хурал нь Олон улсын хүний эрхийн байгууллагаас гаргасан зөвлөмж, дүгнэлтийг парламентаар авч хэлэлцээгүй байна.

АСУУЛТ 8. ОЛОН НИЙТ БА ХҮНИЙ ЭРХИЙН БУСАД БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Сэдвийн тойм

Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газраас нээлттэй парламентыг төлөвшүүлэх, олон нийттэй харилцах үйл ажиллагааныхаа хүрээнд хүний эрхийн талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, хүний эрхийн зөрчил, тулгамдсан асуудлуудыг тандан судлах, илрүүлэх, хүний эрхийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт, үнэлгээ хийх хүрээнд хүний эрхийг хамгаалах байгууллагууд болон иргэд олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудтай олон талт хамтын ажиллагааг хөгжүүлж, хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр идэвхтэй харилцаж байна.

УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо болон холбогдох бусад байнгын хороодоос хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх ХЭҮК-ын илтгэлийг жил бүр тогтмол хэлэлцэж, хүний эрх зөрчигдсөн тодорхой асуудлаар хяналт шалгалт хийх, хүний эрхийн асуудлаар хяналтын болон нээлттэй сонсгол хийх, хуулийн төсөлд хүний эрхийн дүн шинжилгээ хийх байдлаар ажиллаж байна.

УИХТГ-аас УИХ-ын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг тусалцаа үзүүлэх үндсэн чиг үүргийнхээ хүрээнд ХЭҮК-ын илтгэл болон хууль тогтоомжийн төсөлд дүн шинжилгээ хийх, судалгаа, мэдээллээр хангах, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагаандаа хүний эрхийн чиг хандлагыг төлөвшүүлэх, үүнд шаардагдах тогтолцоо, чадавхыг бүрдүүлэхэд анхааран ажиллаж байна. Тухайлбал:

Улсын Их Хурлын Тамгын газраас хэрэгжүүлж буй “Парламентын боловсрол”, “Өсвөрийн парламент” зэрэг олон нийтэд зориулсан хөтөлбөрүүдийн хүрээнд ардчиллын үнэт зүйлс, Үндсэн хууль, хүний эрх, хууль тогтоох байгууллагын талаарх мэдлэг олгох хөтөлбөрийг насны ангиллаар боловсруулж, олон нийтэд нээлттэй хэрэгжүүлж байна. Түүнчлэн УИХ-ын гишүүд болон УИХТГ-ын ажилтнууд, УИХ-ын гишүүдийн ажлын албаны ажилтнуудын хүний эрхийн мэдлэг, хандлагыг сайжруулахад чиглэсэн сургалтын багц хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажилтнуудынхаа хүний эрхийн мэдрэмжтэй хуулийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийн төсөл болон хэрэгжилтэд хүний эрхийн дүн шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйг сайжруулахад анхаарч байна.

УИХ, түүний Тамгын газраас иргэд олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудтай харилцахдаа уламжлалт харилцаанаас гадна сонин, сайт, радио, телевиз зэрэг хэвлэл мэдээллийн суваг, сэтгүүлчдээр дамжуулан харилцахаас гадна сүүлийн жилүүдэд нийгмийн сүлжээний платформуудыг ашиглан УИХ-аас гарч буй шийдвэр, үйл ажиллагаа, өдөр тутмын мэдээ, мэдээллийг түгээх ажлыг идэвхтэй зохион байгуулж, эргэх холбоотой ажиллаж байна.

Тухайлбал, иргэдээс хуулийн төсөлд санал авах d.parliament.mn цахим систем, өргөдөл, мэдээлэл хүлээн авах www.petition.parliament.mn цахим өргөдлийн системийг өнгөрсөн оноос эхлэн ажиллуулж байгаа бөгөөд иргэд эдгээр платформуудыг идэвхтэй ашиглаж байна. Одоогийн байдлаар www.d.parliament.mn цахим системд 180 гаруй хуулийн төсөл байршуулж, давхардсан тоогоор 7 мянга гаруй иргэний саналыг хүлээн авсан бол petition.parliament.mn цахим системд улс орны тулгамдсан асуудлаар одоогийн байдлаар 20 гаруй өргөдөл байршиж, иргэдээс санал цуглуулж байна.

Монгол Улсад 2010 онд Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форум байгуулагдсан бөгөөд эгнээндээ 40 гаруй төрийн бус байгууллагыг нэгтгэсэн энэхүү байгууллага нь Монгол Улсад хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах, зөрчигдсөн эрхийг хамгаалах, Засгийн газарт хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх үүргийг сануулах, санал, шаардлагаа хүргүүлэх зэргээр ажиллаж байна. Тус байгууллагын www.upr-mongolia.mn вэб сайтыг “Глоб Интернэшнл” ТББ ажиллуулж, “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг” (UPR) механизмын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулан ажиллаж байгаа нь хүний эрхийн талаарх төр- иргэний нийгмийн харилцааг бэхжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байна.

8.1. УИХ, түүний Тамгын газраас хүний эрхийн талаар явуулдаг гол олон нийтийн арга хэмжээний талаарх мэдээ, мэдээлэл

УИХ болон холбогдох байнгын хороо

Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хүний эрх, эрх чөлөө, түүний баталгааг хангах үүрэг багтдаг бөгөөд түүний бүрэлдэхүүнд ХЭДХ багтаж байна. Энэ дэд хороо нь УИХ-аас хүний эрхийн талаар явуулах үйл ажиллагаанд тэргүүлэх үүрэгтэй оролцдог бөгөөд УИХ-ын бусад байнгын хороо нь салбарын асуудлаар холбогдох хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Хүний эрхийн дэд хороо нь өнгөрсөн хугацаанд Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх ХЭҮК-ын илтгэлийг хэлэлцэх, тодорхой хүний эрхийн зөрчлийн талаар шалгалт хийх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) хуулийн төсөл, Хууль сахиулах тухай хуулийн төсөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай зэрэг хуулийн төсөлд хүний эрх хэрхэн хангагдаж байгаад дүгнэлт гаргах, бэлгийн дарамт зэрэг хүний эрхийн асуудлаар нээлттэй сонсгол хийх байдлаар ажиллаж ирсэн.

Жишээлбэл, Мөн Хууль зүйн байнгын хороо болон Хүний эрхийн дэд хорооноос 2023.10.25-ны өдөр УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу “Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар хяналтын сонсголыг зохион байгуулж, холбогдох байгууллагууд оролцож, илтгэл хэлэлцүүлж, асуудлаа тодорхойлсон.

Нийгмийн бодлогын байнгын хорооноос 2023.07.05-ны өдөр “Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсэгт заасан хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах” хяналтын сонсголыг зохион байгуулж, асуудлаа тодорхойлсон.

УИХ-ын Тамгын газар

УИХ-ын Тамгын газар нь УИХ болон УИХ-ын байнгын, дэд, түр хороодод мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх хүрээнд дээр дурдсан үйл ажиллагаануудад оролцохын зэрэгцээ олон нийттэй харилцах болон сургалтын үйл ажиллагааны хүрээнд хүний эрхийн талаар үйл ажиллагаануудыг явуулж байна.

Сургалт: УИХ-ын Тамгын газрын зүгээс УИХ-ын гишүүд болон УИХ-ын Тамгын газрын ажилтнуудад сургалтын бодлогоор дамжуулан мэдлэг, мэдээлэл, ур чадварыг байнга нэмэгдүүлдэг билээ. Энэ хүрээнд дараах сургалтуудыг зохион байгуулсан байна. Үүнд:

№	Сургалтын нэр	Хугацаа
1	Хүний эрхэд суурилсан хандлага	2020.12.08
2	Хүний эрхэд суурилсан хандлага	2021.11.04
3	Тэгш эрхийн зарчим ба ялгаварлан гадуурхалтыг хориглох нь	2022.10.31
4	Парламент болон хүний эрхийн үндэсний байгууллагууд хоорондын харилцааны тухай Белградын зарчмуудын талаарх хэлэлцүүлэг	2022.11.21
5	Хүний эрхийн талаарх төрийн үүрэг, хүний эрхийг хамгаалах Олон улсын болон Монгол Улсын тогтолцоо	2022.11.25

6	Ажил эрхлэлт, хөдөлмөрийн хүрээний дарамт, хүчирхийллийг танин мэдэж, урьдчилан сэргийлэх нь	2022.12.23
7	Хүний эрхэд суурилсан бодлого төлөвлөлт	2023.03.03
8	Технологи, хувь хүний мэдээлэл, хүний эрхийн эрсдэл	2023.04.21
9	Хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй парламент: өөрийн үнэлгээ	2023.09.27

Парламентын боловсрол хөтөлбөр: “Парламентын боловсрол” хөтөлбөр хууль тогтоох үйл ажиллагаанд мэдээлэлтэйгээр идэвхтэй оролцдог, хариуцлагатай иргэдийг бэлтгэх, төлөвшүүлэх зорилготой. Хөтөлбөрийн агуулгад парламент гэж юу болохоос эхлээд, парламент ямар үйл ажиллагаа явуулдаг, хууль батлах үйл явц хэрхэн өрнөдөг, үүнд иргэд, хүүхэд, залуучууд хэрхэн оролцох боломжтой байдаг зэрэг өргөн хүрээтэй сэдвүүд багтсан. Мөн хүн бүрийн мэдвэл зохих, бидний хамтын үнэт зүйл болсон Ардчилал, Хүний эрх, Үндсэн хуулийн тухай мэдлэг энэ хөтөлбөрт шингэсэн. Монгол хүн бүрийн бахархал, омогшлыг төрүүлдэг Төрийн сүлд, төрийн дуулал, туг далбаа зэрэг төрийн бэлгэдлийн утга, учрыг сонирхолтой агуулга, хэлбэрээр тайлбарлан тусгасан.

Хөтөлбөрийн агуулгыг 12-14 нас, 15-17 нас, 18-аас дээш гэсэн насны ангиллаар боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлээд байна. Багш, сурагчдад зориулсан гарын авлагууд тусдаа бий.

Өнгөрсөн онд УИХ-аас энэ хөтөлбөрийн 102 сургагч багшийг бэлдсэн. Тэдгээр сургагч багш нар Ерөнхий боловсролын сургууль дээр гарын авлагын дагуу сургалтууд явуулсан. Жишээ нь, Баянзүрх дүүргийн 148 дугаар сургуулийн сургагч багш өөрийн санаачлагаар “Парламентын боловсролын клуб” байгуулж, хичээлийн жилийн туршид маш амжилттай ажилласан. УИХТГ-аас клубын үйл ажиллагаатай очиж танилцсан. Мөн Дархан-Уул аймагт “Өсвөрийн парламент” хоёр жилийн турш ажилласан гэх мэт сайн туршлагууд нэмэгдсээр байна.

Хуулийн төсөл боловсруулагчдын сургалт: Улсын Их Хурлын Тамгын газраас Монголын Хуульчдын холбоо, Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран (2023.05.24-05.26) Хуулийн төсөл боловсруулагчдын сургалтыг зохион байгуулжээ.

Сургалтаар хуулийн төсөл боловсруулагчид хууль, хууль зүйн техникийн талаар суурь ойлголтоос эхлээд хуульд тавигддаг агуулгын болон хэлбэрийн шаардлага, төсөл боловсруулах арга ажиллагаа, эрх зүйн рецепци, хууль тогтоомжийн системчлэл зэрэг зайлшгүй тулгамддаг олон асуудлыг эрх зүйн онол, практикийн үүднээс иж бүрнээр авч үзэхийн зэрэгцээ хүний эрхэд суурилсан хандлага, хууль тогтоомжийн төслийн хүний эрхийн үнэлгээний талаар мэдлэг, мэдээллийг авсан.

Тус сургалтад Улсын Их Хурлын Тамгын газрын хуулийн төслийн эхийг баригч, хуульч нар, мөн төрийн захиргааны төв байгууллагуудын Хууль, эрх зүйн газар, хэлтсийн ажилтнуудаас бүрдсэн 50 хуульч, эрх зүйч хамрагдсан бөгөөд оролцогчдод 3.0 кредит олгож, батламж гардуулсан юм. Энэ сургалт нь цаашид тогтмол үргэлжлэх юм.

8.2. УИХ-аас ХЭҮК-ын илтгэлийг хэрхэн авч хэлэлцсэн талаарх мэдээлэл

УИХ-аас ХЭҮК-ын тайлан илтгэлийг авч хэлэлцүүлэх тухай Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний Комиссын тухай хуулиудын дагуу авч, хэлэлцэж байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг Улсын Их Хурал жил бүр хэлэлцэх тухай, мөн 16.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлд Улсын Их Хурлын Тамгын газраас шинжилгээ хийж, шинжилгээ хийсэн талаарх танилцуулгыг холбогдох Байнгын хороонд хүргүүлэх тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2.3 дахь хэсэгт заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг Хууль зүйн байнгын хороо болон холбогдох бусад байнгын хороо хаврын ээлжит чуулганы хугацаанд хэлэлцэх тухай, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд хүргүүлэх тухай, мөн 9.2 дахь хэсэгт Комиссын илтгэлийг жил бүрийн Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, илтгэлээр өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар **Улсын Их Хурал тогтоол** гаргах тус тус хуулийн заалттай бөгөөд үүний дагуу хэрэгжүүлж байна.

УИХ нь тогтоол гаргахдаа ХЭҮК-ын илтгэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр ЗГ-т чиглэл өгдөг бөгөөд хэрэгжилт нь зарим талаар хангалтгүй байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль 2020 онд шинэчлэн батлагдсан бөгөөд түүнээс хойш хугацаанд Хүний эрхийн Үндэсний Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20, 21, 22 дахь илтгэлүүдийг бэлтгэн УИХ-д хүргүүлж, хэлэлцүүлсэн байна. Үүнд:

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэл:

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэл болон тус илтгэлд Улсын Их Хурлын Тамгын газраас шинжилгээ хийсэн танилцуулгын хамт Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтсон.

Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэн.

Комисс нь 2 илтгэл нийт 63 санал, зөвлөмжийг Улсын Их Хуралд хүргүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолыг баталсан. Тус илтгэлүүдэд ХЭҮК-оос нийт 40 санал зөвлөмж гарсан.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл:

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл болон тус илтгэлд Улсын Их Хурлын Тамгын газраас шинжилгээ хийсэн танилцуулгын хамт Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтсон.

Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг хэлэлцсэн.

Комисс нь нийт 30 санал, зөвлөмжийг Улсын Их Хуралд хүргүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 49 дүгээр тогтоолыг баталсан.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл:

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 04

дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтсон.

Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг хэлэлцсэн.

Комисс нь нийт 43 санал, зөвлөмжийг Улсын Их Хуралд хүргүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолыг баталсан.

8.3. Парламентаас иргэний нийгмийн байгууллагуудтай тогтмол харилцдаг суваг, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл

Улсын Их Хурал нь УИХТГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газраараа дамжуулан иргэд олон нийт болон иргэний нийгмийн байгууллагуудтай уламжлалт хэвлэл мэдээллийн суваг болох сонин, сайт, радио, телевиз, сэтгүүлчдээр дамжуулан харилцахын зэрэгцээ нийгмийн сүлжээний платформуудыг ашиглаж өдөр тутмын мэдээ, мэдээллийг идэвхтэй түгээж байна.

Мөн 2022 оны 07-р сарын 05-ны өдөр УИХ-ын тухай хуульд УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэд, олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах (МУИХТХ 39¹.1-39¹.3) нэмэлт, өөрчлөлт оруулан ажиллаж байна. Ингэхдээ d.parliament.mn болон petition.parliament.mn системээр дамжуулан хуулийн төсөлд санал авч, улс орны тулгамдсан асуудлын талаарх цахим өргөдлийг иргэдээс хүлээн авч байна.

УИХ-ын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах суваг

Өнөөгийн байдлаар Улсын Их Хурал, түүний Тамгын газрын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах хүрээнд дараах байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Өдөр тутмын сонин

- | | |
|-------------------|----------------------|
| 1. “Өнөөдөр” | 3. “Өглөөний шуудан” |
| 2. “Өдрийн сонин” | 4. “Зууны мэдээ” |

Цахим сайт

5. Zarig.mn	14. Mpress.mn	23. Time.mn
6. Gogo.mn	15. See.mn	24. Isee.mn
7. News.mn	16. Focus.mn	25. Eguur.mn
8. 24tsag.mn	17. Ivoice.mn	26. Times.mn
9. Ikon.mn	18. Zindaa.mn	27. Ublife.mn
10. Itoim.mn	19. Tovch.mn	
11. Ubn.mn	20. Newspress.mn	
12. Mand.mn	21. Ergelt.mn	
13. Livetv.mn	22. Zuv.mn	

Радио

28. МҮОНРадио FM 106.0	29. ЭмЖиЭл радио FM 88.3
------------------------	--------------------------

Телевиз

30. МҮОНТВ	36. ETV	42. Парламент ТВ
31. Eagle TV	37. TM	43. Малчин ТВ
32. NTV	38. TV8	44. C1
33. TV9	39. TM	45. Сүлд
34. TV5	40. Channel 11	
35. MN25	41. TV 2	

Парламентын сэтгүүлчид

Улсын Их Хурал, түүний Тамгын газрын үйл ажиллагааг сурвалжлах эрх бүхий сэтгүүлчдэд сурвалжлах үнэмлэх олгодог. 2023 оны 10 дугаар сарын байдлаар 280 гаруй парламентын сэтгүүлч, зурагчин, зураглаач Төрийн ордноос сурвалжилга хийж байна.

Бусад байгууллага

“Улсын Их Хурал – Энэ 7 хоногт” тойм нэвтрүүлэг бэлтгэхэд “Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо” ТББ-тай гэрээ байгуулж, сонсголын бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах зорилтын хүрээнд 7 хоног бүр бэлтгэдэг нэвтрүүлэг дохионы хэлмэрчтэй олон нийтэд хүрдэг. Түүнчлэн, Төрийн ордонд зохион байгуулагдах олон нийтийн арга хэмжээнд дохионы хэлний хэлмэрчтэй хамтран ажилладаг.

Цахим хуудас

Улсын Их Хурлын parliament.mn цахим хуудсыг хөгжүүлэхэд Айдиа Девелопмент ХХК-аар гүйцэтгүүлж, харааны бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах хүрээнд тус цахим хуудсанд байршуулагдсан мэдээ мэдээллийн үсгийн хэмжээг томруулах боломжтойгоор захиалга өгч,

хэрэгжүүлсэн. Мөн Улсын Их Хурлаар батлагдсан хуулиудыг харааны бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах хүрээнд аудио хэлбэрт хувирган байршуулсан.

Нийгмийн сүлжээний хаяг

Улсын Их Хурлын Тамгын газраас УИХ-аас гарч буй хууль, тогтоомж, шийдвэр, үйл ажиллагааны талаар нийгмийн сүлжээний Facebook, X (twitter), Instagram цахим аппликейшн, платформуудыг идэвхтэйгээр ашиглаж иргэд, олон нийтэд мэдээллийг байнга хүргэж байна. Одоогийн байдлаар Facebook хаяг 69 мянга, X (twitter) хаяг 32 мянга, Instagram хаяг 2 мянга тус тус дагагчтайгаар УИХ-ын мэдээ, мэдээллийг хүргэж байна.

D.PARLIAMENT.MN болон PETITION.PARLIAMENT.MN систем

Тус системүүд нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39¹ дүгээр зүйлд заасны дагуу Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангах хүрээнд хийгдсэн юм.

Системүүдийн зорилго нь хууль тогтоох үйл хэрэгт олон нийтийн санал бодлыг тусгах, иргэдийн эрх ашигт нийцсэн бодлого, шийдвэрийг гаргахад тэдний дуу хоолойг хүргэх, ард олны засаглах эрхийг вэб болон аппликейшнаар дамжуулан хангахад оршиж байна.

D.parliament.mn цахим систем нь УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022.05.25-ны өдрийн 321 дүгээр захирамжаар батлагдсан “D.PARLIAMENT” цахим системийг эрхлэн хөтлөх журмын дагуу ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар нийт 180 орчим хуулийн төсөл (идэвхтэй боловсруулагдаж байгаа 49)-д 7 мянга гаруй иргэд давхардсан тоогоор санал өгсөн байна.

Petition.parliament.mn цахим систем нь Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2023.01.18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим систем ашиглан иргэдийн оролцоог хангах, санал авах журам”-ын дагуу ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар 20 гаруй цахим өргөдөлд иргэдээс идэвхтэй гарын үсэг цуглуулж байна.

Монголын Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форум

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлыг дүгнэн хэлэлцэхтэй холбогдуулан 2010 оны 01 дүгээр сард төрийн бус байгууллагуудын дунд зохион байгуулсан сургалтын үр дүнд Монголын хүний эрхийн ТББ-уудын Форум байгуулагдсан юм.

Тэр цагаас хойш Хүний эрхийн ТББ-уудын Форум эгнээндээ 40 гаруй ТББ-ыг нэгтгэн Монгол Улсад хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах, хөхиүлэн дэмжих, зөрчигдсөн эрхийг хамгаалах чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

Форум нь анх Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR - Universal Periodic Review) хэмээх цоо шинэ механизмыг Монгол Улсын хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулахад үр дүнтэй ашиглахыг эрмэлзэж байгуулагдсан бол одоо хүний эрхийн асуудлаар үр дүнтэй хамтран ажилладаг, Засгийн газарт хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх үүргийг сануулж, алдаа дутагдлаа засаж залруулахыг шаарддаг, НҮБ-ын хүний эрхийн бусад механизмыг ч үр дүнтэй ашиглахыг зорьж буй, хүний эрхийн хамгийн олон ТББ-ыг эгнээндээ нэгтгэсэн, хүний эрхийн өргөн хүрээний асуудлаар ажилладаг сайн дурын холбоо болж өргөжсөн.

www.upr-mongolia.mn вэб сайтыг Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR) хэмээх шинэ механизмын тухай олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, энэ асуудлаарх нийгмийн үзэл бодлыг төлөвшүүлэх зорилгоор Австралийн Засгийн газрын Хүний эрхийн жижиг тэтгэлгийн хөтөлбөр, Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр хэрэгжүүлсэн “UPR-ийг мэдээлэл, сурталчилгаагаар хангах нь” төслийн хүрээнд 2010 онд нээж “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага хариуцан ажиллуулж байна.

Вэб сайт дахь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн гаргасан шийдвэрүүд, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг – UPR явуулах удирдамж зэрэг Хүний эрхийн зөвлөлийн бусад баримт бичгийг “Хүний эрх хөгжил” төв монгол хэлнээ орчуулан бэлтгэсэн юм.

Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд (2017.03.15-ны байдлаар шинэчилсэн)

1. Айвуун
2. Байгаль орчин эрүүл мэнд төв
3. Бодлогод залуусын хяналт
4. Булаг шанд мөрний эхийг хамгаалах сан
5. Бүсгүйчүүд 21-р зуун
6. “Бүх нийт боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвсэл
7. Глоб интернэшнл төв
8. Гүнж төв
9. Залуус эрүүл мэнд төв
10. Захиргааны шинэ санаачилга
11. Заша Өвс Төв
12. Зориг сан
13. Зөвт ёс

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

14. Иргэдэд туслах хүний эрхийн төв
15. Ирээдүйн босго
16. Их Бага Баяншарга
17. Казах эмэгтэйчүүдийн Арулар холбоо
18. ЛГБТ төв
19. Митчелл сан
20. Монголын Дүлий Иргэдийн Үндэсний Холбоо
21. Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Холбоо
22. Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбоо
23. Монголын Эмнести интернэшнл
24. Монголын Эмэгтэйчүүдийн Хөдөлмөрийг Дэмжих Холбоо
25. Монголын эрэгтэйчүүдийн холбоо
26. МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээ
27. Ногоон соёл иргэншил хөгжил сан
28. Мэдээллийн Орхон XXI зуун төв
29. Оюу Толгойн хяналт
30. Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүдийн клуб
31. Саяана Сайн Сайхны нийгэмлэг
32. Сэтгэлзүйн мэдрэмж
33. Татварт иргэний хяналт
34. Төр иргэн түншлэл
35. Тува эмэгтэйчүүдийн “Авам” холбоо
36. Тулгат залуу гэр бүл
37. Түгээмэл хөгжил төв
38. Үндсэн уртраг
39. Хар тамхи мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг
40. Хил хязгааргүй алхам
41. Хил хязгааргүй гол мөрөн
42. Хөгжлийн хэлхээ төв
43. Хууль хүний эрх төв
44. Хүйсийн тэгш эрхийн төв
45. Хүний аюулгүй байдлын судалгааны төв
46. Хүний эрх хөгжил төв
47. Хүнсний тусгаар тогтнолын төлөө Хүнс эвсэл
48. Хүүхдийн Эрх Хамгаалал Төв
49. Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв
50. Хэрэглэгч сан
51. Эвт сайн хөрш

Сүүлийн байдлаар ХЭҮК-оос иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлтэй “Цахим орчинд хүний эрхийг хамгаалах”, “Төр, иргэний нийгмийн түншлэлийн асуудал”-аар санал солилцох, зөвлөлдөх уулзалтыг 2023 оны 03 дугаар сард зохион байгуулсан.

Зөвлөлдөх уулзалтын үеэр Иргэний нийгмийн зөвлөл болон Хүний



эрхийн форумын гишүүн байгууллагын зүгээс Цахим орчинд хүний эрхийг хамгаалах тухай хуультай холбогдуулан олон улсын сайн туршлагыг судлах, хуулийн нэр болон цахим орчин дахь зөрчилтэй контент гэдгийг оновчтой тодорхойлох, хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахаас сэргийлэх зэрэг асуудлаар санал илэрхийллээ.

Уулзалтад ХЭҮК-ын дарга Ж.Хунан, Комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн С.Дондов, Комиссын гишүүн Х.Мөнхзул, Г.Нарантуяа, Б.Энхболд болон дараах төлөөлөл оролцов.

Уулзалтад хүрэлцэн ирсэн Хүний эрхийн форумын гишүүн байгууллагууд. Үүнд:

1. ЗГХЭГ-ын Хүний эрхийн дэд хорооны ажилтан М.Баянжаргал
2. “Эмнести интернейшнл” ТББ-ын гүйцэтгэх захирал Б.Алтантуяа
3. “Эмнести интернейшнл” ТББ-ын компанит ажлын зохицуулагч Г.Амарзаяа
4. “Эмнести интернейшнл” ТББ-ын Өсөлт, хөгжилт хариуцсан зохицуулагч Г.Сүхбат
5. “Цогц Хөгжлийн Үндэсний Төв”-ийн гүйцэтгэх захирал М.Энхбадрал
6. Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн. Нийгмийн бодлогын Хорооны зөвлөх. Европ дахь Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны тэргүүн Д.Амараа
7. Монголын Улс Төрийн Хэлмэгдэгсдийн Холбоо Х.Мөнхбаяр
8. Эрдэм сургалт судалгааны хүрээлэн ТББ-ын захирал Б.Өлзийсайхан
9. Монголын эрэгтэйчүүдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн М.Чинзориг
10. Монголын ахмадын холбооны Ажлын албаны ахлах мэргэжилтэн Б.Цэцэгсүрэн
11. “ЛГБТ Төв” ТББ-ын гүйцэтгэх захирал Э.Энхмаа
12. “Хөгжил төв”-ийн тэргүүн Г.Уранцоож
13. “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хэрэглэгчийн мэдээллийн сан” ТББ зохицуулагч Г.Оюунтуяа
14. “Сэтгэл зүйн мэдрэмж” ТББ-ын тэргүүн Ч.Сэмжидмаа
15. “Эмэгтэйчүүд амьдрал” ТББ-ын Тэргүүн Ж.Адъяа
16. “Түгээмэл эрх хөгжил” ТББ-ын тэргүүн Т.Саруул
17. “Баяншарга” ТББ-ын тэргүүн Л.Борхүү
18. “Оюу толгойн хяналт” ТББ-ын тэргүүн Д.Сүхгэрэл
19. Хөгжлийн хэлхээ ТББ-ын тэргүүн А.Долгор
20. “Саяана сайн сайхны нийгэмлэг” Д.Мөнхсайхан
21. Хэвлэлийн хүрээлэнгийн захирал М.Мөнхмандах
22. Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжинэ нийгэмлэг Ш.Ариунаа
23. Бие даасан шинжээч Д.Сүхжаргалмаа

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль, тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын Чуулганы хуралдааны дэгийн тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль
- Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам, МУЗГ-ын 2017.07.04-ний өдрийн 193-р тогтоол.
- Монгол Улсын дээд шүүхийн “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” 2008 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 09 дүгээр тогтоол;

Олон улсын баримт бичиг:

- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц;
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт;
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт;
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц;
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц;
- Хүүхдийн эрхийн тухай конвенц;
- Бүх цагаач ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц /Монгол Улс хараахан соёрхон батлаагүй/;
- Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц.

Ном, гарын авлага:

- United Nations General Assembly, International Convention on the Protection of the Rights of All Migrant Workers and Members of Their Families, 18 Dec 1990;
- О.Мөнхсайхан, Р.Очирбал, “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл” (тойм судалгаа), Улаанбаатар хот, 2021 он;
- УИХТГ, “Хүний эрхийн дэд хороо хүний эрхийн талаар болон Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн асуудлаар мэдээлэл сонслоо” веб мэдээ, Дэлгэрэнгүйг: <https://www.parliament.mn/nn/15266/> ;
- Б.Болорсайхан, “Хүний эрхийн үндэсний байгууллагыг үнэлэх нь” нийтлэл, “Хүний эрх” онол арга зүйн сэтгүүл (2014/02), Улаанбаатар хот, 2014 он;

- Магадлан итгэмжлэх дэд хороо, Цахим хуралдааны тайлан, зөвлөмж, 2021 оны 10 дугаар сарын 18-29 -ний өдрийн хуралдаан. 12-15 дахь тал. Дэлгэрэнгүйг: https://ganhri.org/wp-content/uploads/2021/12/SCA-Report-October-2021_EN.pdf
- Хүний эрхийн Үндэсний Комисс, Танилцуулга. Дэлгэрэнгүйг: <https://nhrcm.gov.mn/>;
- УИХ-ын 2021-2023 оны ээлжит болон ээлжит бус чуулганы үйл ажиллагааны танилцуулгууд;
- Конрад-Адэнауэр-Сан, МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхим, “Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа” Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж, Улаанбаатар хот, 2020 он;
- Хүний эрхийн Үндэсний Комисс, Танилцуулга. Дэлгэрэнгүйг: <https://nhrcm.gov.mn/>;
- ЗГХЭГ, “Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлын тайланг илтгэж эхэллээ” мэдээ. Дэлгэрэнгүйг: <https://cabinet.gov.mn/8984.html>;
- Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд нээлттэй хяналт шалгалт хийсэн тайлан, дүгнэлт, зөвлөмж. дэлгэрэнгүйг: <https://irgen-tur.mn/mn/blog/ogp/single/209>;
- Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийн хороо, НҮБХХ “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц” хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, Улаанбаатар хот, 2011 он;
- Стратеги Академи, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр хэрэгжсэн талаарх түргэн үнэлгээ, Улаанбаатар хот, 2022 он;

Цахим эх сурвалж:

- www.petition.parliament.mn
- www.d.parliament.mn
- www.upr-mongolia.mn
- <https://www.ohchr.org/en/core-international-human-rights-instruments-and-their-monitoring-bodies>;
- <https://www.ohchr.org/en/hrbodies/hrc/home>;
- <https://www.ohchr.org/en/hr-bodies/upr/basic-facts>;
- <https://upr-mongolia.mn/images/xupld/51mon.pdf>;
- <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G23/129/21/PDF/G2312921.pdf>;
- <https://www.ohchr.org/en/statements/2021/12/united-nations-special-rapporteur-violence-against-women-its-causes-and> ;
- <https://www.ohchr.org/en/statements/2019/09/end-mission-statement-independent-expert-effects-foreign-debt-visit-mongolia>
- <https://www.ohchr.org/en/statements-and-speeches/2019/05/visit-mongolia-30-april-13-may-2019-end-mission-statement> ;
- <https://www.ohchr.org/en/statements/2017/09/statement-united-nations-special-rapporteur-john-h-knox-conclusion-his-mission>.